




2026 ОНЫ 9-Р САРЫН 10

Ширхэгт боловсруулах стандарт

ХУВИЛБАР 2.0



ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ

Хариуцлагаас чөлөөлөх мэдэгдэл

SFA-ийн «Ширхэгт боловсруулах» стандарт, түүнд иш татсан бусад баримт бичиг болон мэдээллийн эх сурвалжийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлын талаар ямар нэгэн баталгаа, батлан даалт, мэдэгдэл гаргаагүй болно. Уг стандартыг мөрдөх нь дэлхийн, үндэсний, улсын болон орон нутгийн засаг захиргааны хууль тогтоомж, дүрэм журам, захирамж буюу бусад холбогдох шаардлагыг орлох, зөрчих, өөрчлөх зорилгогүй бөгөөд тэдгээрийг орлохгүй, зөрчихгүй, өөрчлөхгүй. SFA-ийн «Ширхэгт боловсруулах» стандартыг мөрдөх нь сайн дурын үндсэн дээр хэрэгжих бөгөөд SFA болон/эсхүл түүний гишүүд, оролцогч талуудын эсрэг хууль ёсоор хэрэгжүүлэх боломжтой аливаа үүрэг, эрхийг үүсгэх, тогтоох, хүлээн зөвшөөрөх зорилгогүй бөгөөд ийнхүү үүсгэхгүй. Хэрэглэгчид уг Стандартыг мөрдөөгүй гэсэн үндэслэлээр SFA болон/эсхүл түүний гишүүд, оролцогч талуудын эсрэг хууль зүйн нэхэмжлэл гаргах эрхгүй.

Please note: The Mongolian translation is provided to support stakeholder participation in the public consultation. In the event of any conflict or inconsistency between the English and Mongolian versions of this draft Standard, the English version shall prevail.

SFA-ийн тухай

SFA нь малчин, бэлтгэн нийлүүлэгчээс эхлээд жижиглэн худалдаа эрхлэгч хүртэлх малын гаралтай ширхэгтийн нийлүүлэлтийн сүлжээтэй хамтран ажилладаг ашгийн бус олон улсын байгууллага юм. Бидний алсын хараа бол хүн, амьтан, байгаль орчны эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалсан, хариуцлагатай, хүртээмжтэй дэлхийн байгалийн ширхэгтийн салбарыг бий болгоход оршино. SFA-ийн «Ширхэгт боловсруулах» стандарт (цаашид «Стандарт» гэх) нь тасралтгүй сайжруулалт; үр дүнтэй засаглал, удирдлага; шударга, зохистой хөдөлмөр; эрүүл мэнд, аюулгүй байдал; байгаль орчин, химийн бодисын менежмент; чанар болон нийлүүлэлтийн сүлжээний менежмент зэрэг үндсэн зарчмуудаас бүрдэнэ.

Энэхүү Стандартын тухай

Энэ бол норматив баримт бичиг бөгөөд SFA нь SFA-ийн Стандарт боловсруулах журамд заасны дагуу хөгжин өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлага, шинээр бий болж буй шилдэг туршлагад үндэслэн үүнд өөрчлөлт оруулах эрхээ хадгална. SFA-ийн албан ёсны хэл нь англи хэл тул орчуулгын талаарх тодруулгыг англи хэл дээрх эх бичвэрээс баталгаажуулан лавлавал зохино. Энэхүү Стандартын хамгийн сүүлийн хувилбартай эсэхээ шалгана уу. SFA-ийн цахим хуудсанд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Стандартыг үргэлж байршуулсан байна.

Энэхүү хувилбар нь хамрах хүрээгээ өргөжүүлж, малын гаралтай ширхэгтийг ерөнхийд нь хамруулсан бөгөөд аливаа төрлийн малын гаралтай ширхэгтэд хамаарна (тодорхойлолтыг үзнэ үү). Мөн малын гаралтай ширхэгтийн хоёрдогч боловсруулалтын нойтон боловсруулалтын үе шатуудад хамаарна. Түүнчлэн малын гаралтай ширхэгтийн хэрэглээнээс өмнөх болон хэрэглээний дараах дахин боловсруулалтыг хамарна. Энэхүү стандарт нь хувцас, гоёл чимэглэл, дэвсгэр хэрэглэл, эсхүл малын гаралтай ширхэгтэд суурилсан бусад бүтээгдэхүүнийг оёх/үйлдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй. Шаардлагуудыг ерөнхий түвшинд томьёолсон бөгөөд үйлдвэрүүд хэрэглэгчийн шаардлагыг хангахын тулд өөрсдийн шилдэг туршлагыг нэвтрүүлэх, хөгжүүлэх боломжийг үлдээсэн болно. Салбар тогтвортой хөгжлийн замаар урагшлан хөгжихийн хэрээр ирээдүйн дахин хяналтад нэмэлт сайжруулалт хийхээр төлөвлөж, салбарыг ирээдүйд бэлтгэх зорилгоор зарим шалгуурыг оруулсан болно.

Энэхүү хувилбар нь шаардлагыг дараах байдлаар өргөжүүлсэн:

- Засаглал болон нийлүүлэлтийн сүлжээний менежментийг бэхжүүлсэн — үүнд дотоод аудит, тасралтгүй сайжруулалт болон сөрөг үр нөлөөний үнэлгээний талаарх шинэ заалтууд (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага OECD-тэй уялдуулсан магадалгаа) багтсан бөгөөд [Хавсралт 1](#), and [2-т зааврын хэлбэрээр дэлгэрэнгүй тусгасан](#);
- Нөөцийн ашиглалтын сайжруулалтын үзүүлэлт — ус, эрчим хүчний менежментийн хувьд;
- Хаягдал, ялгаруулалт болон бохир усны менежментийн сайжруулалтын үзүүлэлт;
- Жендерийн тэгш байдлын шинэ шаардлага (SFA-ийн хийсэн судалгаанд тулгуурласан, олон улсын конвенцуудад үндэслэсэн);
- Хүүхдийн хөдөлмөрийг хамарсан өргөтгөсөн шаардлага — ILO-гийн конвенцуудтай уялдуулсан;
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (OSH) өргөтгөсөн шаардлага — хэт ягаан туяанд өртөх байдал, эрсдэлийн үнэлгээ;

- Сайтар боловсруулсан химийн бодисын менежментийн тогтолцоо — аж ахуйн нэгж нь дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой тогтолцоо болон RSL жагсаалтуудаас сонгох боломжийг олгосон заалттай.

Бусад өөрчлөлтөд алт, мөнгө, хүрэл оноо олгох тогтолцоо болон байгууллагыг эрэмбэлэх гэрлэн дохионы тогтолцоог хассан явдал багтах бөгөөд тэдгээрийн оронд SFA-ийн «Малын гаралтай ширхэгт» стандарт (AFS)-ын тасралтгүй сайжруулалтын хүрээтэй уялдуулсан.

Энэхүү дахин хяналтаар тогтоосон нэмэлт шаардлагууд дараах олон улсын гэрээ, зааварт үндэслэсэн болно:

- Хувцас, гутлын салбар дахь хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний талаарх OECD-ийн магадалгааны заавар;
- OECD (2018) OECD Due Diligence Guidance for Responsible Business Conduct, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/15f5f4b3-en>;
- ILO-гийн 100 дугаар конвенц (Тэгш цалин хөлс);
- ILO-гийн 111 дүгээр конвенц (Хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн ялгаварлан гадуурхалт);
- ILO-гийн 138 дугаар конвенц (Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар);
- ILO-гийн 182 дугаар конвенц (Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд);
- ILO-гийн 183 дугаар конвенц (Жирэмсэн, амаржсан эхийг хамгаалах);
- ILO-гийн 190 дүгээр конвенц (Хүчирхийлэл, дарамт);
- ЕХ-ны хэрэглэгчийн аюулгүй байдал, бүтээгдэхүүний тохирлын зарчмууд;
- ZDHC/OEKO-Tex/Bluesky химийн бодисын менежментийн зарчмууд.

Энэхүү Стандартын чанарын зорилтуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Стандартын нөхцөл, шаардлагаас үзэж болно.

Энэхүү Стандартыг нийтлэг хэрэглээний шаардлагыг хамарсан Хэсгүүдэд ([1-9](#), [17](#), [18](#), [19 дүгээр Хэсэг](#)) хуваан зохион байгуулсан бөгөөд эдгээр нь нэг хамрах хүрээний гэрчилгээнд багтсан бүх үйл ажиллагаанд хамаарна. Анхан шатны боловсруулалтад тавих нэмэлт шаардлагыг [10](#), [11](#), [12 дугаар Хэсэгт](#); хоёрдогч боловсруулалтыг [13 дугаар Хэсэгт](#); дахин боловсруулсан ширхэгтийг [14](#), [15](#), [16 дугаар Хэсэгт](#) тус тус тусгасан. Үүнийг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Үйл явц	Холбогдох хэсгүүд
БҮГД	1-9 , 17 , 18 , 19 дүгээр Хэсэг Хавсралт 1-5 ба 7
Зөвхөн анхан шатны боловсруулалт	1-9 , 17 , 18 , 19 дүгээр Хэсэг ; 10 , 11 , 12 дугаар Хэсэг Хавсралт 1-5 ба 7
Зөвхөн хоёрдогч боловсруулалт	1-9 , 17 , 18 , 19 дүгээр Хэсэг ; 13 дугаар Хэсэг Хавсралт 1-5 ба 7

Анхан шатны болон хоёрдогч боловсруулалт	1-9, 17, 18, 19 дүгээр Хэсэг ; 10, 11, 12 дугаар Хэсэг Хавсралт 1-5 ба 7
Ширхэгтийг дахин боловсруулах	1-9, 17, 18, 19 дүгээр Хэсэг ; 14, 15, 16 дугаар Хэсэг Бүх хавсралт

Энэ нь модуль хэлбэрийн хандлага бөгөөд аж ахуйн нэгж нь а) зөвхөн анхан шатны боловсруулалтаар баталгаажих, эсхүл б) өөрийн үйл ажиллагаанд хамаарах нэг буюу хэд хэдэн хоёрдогч боловсруулалтын үе шатыг хамруулах аль нэгийг сонгож болно. Гэвч Стандартын хамрах хүрээнд багтах бөгөөд өөрийн аж ахуйн нэгжид явагдаж буй бүх үйл ажиллагааг хамруулсан байх шаардлагатай. Мөн үйл ажиллагааныхаа хүрээг хамрах хүрээний гэрчилгээндээ тодорхой заан сонгосон байна.

Энэ бол дэлхий нийтийн Стандарт юм. Иймд үндсэн болон сайжруулалтын зарим шаардлага (үзүүлэлт) улс бүрийн хууль тогтоомжийн хүрээнд хамаарахгүй байж болно. Юуны өмнө аж ахуйн нэгж болон түүний худалдааны түншүүдэд хамаарах үндэсний бүх хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөх нь чухал.

SFA нь сайжирч буй болон тэргүүлэгч үйлдвэрүүдийн өмнө тулгарч буй боломж, сорилтыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд шаардлагатай тохиолдолд эрсдэлд суурилсан хандлагыг баримталснаар энэхүү стандартын хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгийг тасралтгүй сайжруулалтын хүрээнд хангах боломжийг олгодог. Үйлдвэрүүд зорилтоо биелүүлэх замаар илүү хүчтэй үр нөлөө үзүүлэхийн тулд өсөлт, сайжруулалтын зорилтоо өөрсдөө сонгож чадна.

Заавал биелүүлэх бүх шаардлагыг (үзүүлэлтийг) хангасан үйлдвэрүүд «SFA certified» статус авах эрхтэй. Аль нэг аудитаар заавал биелүүлэх бүх шаардлага болон сайжруулалтын бүх үзүүлэлтийг хангасан үйлдвэрүүд тухайн аудитын дараа «SFA Best Practice» гэж баталгаажиж болно; харин энэхүү Стандартын бүх шаардлагыг хангасан үйлдвэрүүд SFA-ийн тэргүүлэгч үйлдвэрээр хүлээн зөвшөөрөгдөж, SFA-ийн салбарын тэргүүлэгчээр баталгаажихаас гадна аудитын давтамжид хөнгөлөлт эдлэх боломжтой.

Энэхүү баримт бичигт шаардлага, зөвлөмж, зөвшөөрөл болон боломж буюу чадварыг илэрхийлэхэд дараах нэр томъёог хэрэглэв:

- «shall» — норматив шаардлагыг заана;
- «should» — зөвлөмжийг заана;
- «may» — зөвшөөрлийг заана;
- «can» — боломж буюу чадварыг заана; мөн
- «justify» буюу «justified» гэдэг нь аж ахуйн нэгжийн тохирлын үнэлгээний байгууллагад үндэслэлээ гаргахыг хэлэх бөгөөд үндэслэл гаргаж буй үйл ажиллагаа нь жишгээс гажсан онцгой тохиолдол болохыг илэрхийлнэ.

 **Заавар болохыг заана. Заавар нь өөрөө норматив шинжтэй биш боловч норматив шаардлагыг давтан хэлэх, бэхжүүлэх ба/эсхүл тодруулж болно.**

Ашигласан эх сурвалж

SFA-ийн хөтөлбөрийн бусад баримт бичиг:

- [SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт](#)
- [SFA-ийн Малын гаралтай ширхэгтийн стандарт](#)
- [«Цэвэр ноолуур боловсруулах» стандарт v 1.0](#)
- [Дүрслэлт мэдэгдлийн гарын авлага](#)
- [SFA-ийн Үнэлгээ, баталгаажуулалтын гарын авлага](#)
- [SFA-ийн Нэр томьёоны тайлбар толь](#)
- [SFA-ийн Стандарт боловсруулах журам](#)

SFA-ийн цахим холбоос

- [SFA – Тохирлын үнэлгээний байгууллагууд](#)
- [SFA-ийн Мөшгөлтийн платформ](#)

Хамтран ажиллах

«SFA Certified» малын гаралтай ширхэгт үйлдвэрлэж, худалдаалж эхлэхийн тулд та гуравдагч талын аудитын үр дүнд үндэслэн энэхүү Стандартын дагуу баталгаажсан байх шаардлагатай. Баталгаажуулалтын ач холбогдол болон хаанаас эхлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахад зориулж бид «[Get Certified](#)» цуврал гарын авлагыг боловсруулсан.



Энэхүү баримт бичгийн дахин хяналт

Энэхүү Стандартыг SFA хариуцна. Энэхүү Стандартын бүтэц, боловсруулалт болон/эсхүл хэрэгжилт, түүнчлэн SFA-ийн хөтөлбөрийн бусад аль ч хэсэгтэй холбоотой санал, гомдлыг SFA-ийн Нээлттэй хэлэлцүүлгийн порталаар дамжуулан ирүүлбэл зохино. Бүх саналыг нягтлан авч үзэх бөгөөд үүнийг өмнөх томоохон хувилбарыг нийтэлснээс хойш таван жилийн дотор эхлэхээр товлогдсон, энэхүү баримт бичгийн албан ёсны дахин хяналт эхлэхээс хэтрэхгүй хугацаанд гүйцэтгэнэ.

Хүчин төгөлдөр болох огноо

Аж ахуйн нэгжүүд энэхүү Стандартыг нийтэлсэн огнооноос эхлэн баталгаажуулалт хүсэхээр сонгож болно.

Энэхүү стандарт 2027 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр болно (хүчин төгөлдөр болох огноо). 2029 оны 8 дугаар сарын 28-ны өдөр хүртэл 18 сарын шилжилтийн хугацаа үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд бүх байгууллага уг стандартын дагуу үнэлгээнд хамрагдсан байна.

[«Цэвэр ноолуур боловсруулах» стандарт v 1.0-ын](#) дагуу аль хэдийн баталгаажсан аливаа аж ахуйн нэгж шилжилтийн хугацааны аль ч үед «Ширхэгт боловсруулах» стандартын дагуу үнэлгээнд хамрагдаж болно.

Бүх аж ахуйн нэгж 2029 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн дотор энэхүү стандартын дагуу баталгаажсан байхаар тооцно.

Өөрчлөлтийн бүртгэл

Хувилбар	Агуулга	Дахин хяналт	Нийтлэгдсэн огноо
1.0	Амьтны гаралтай утас боловсруулахад ашиглагддаг хортой бодисууд, ялангуяа алкилфенол этоксилатуудын (APEOs) байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах зорилгоор боловсруулсан.	Хамаарахгүй	27/08/2021
2.0	Энэхүү стандартыг ISEAL-ийн дүрэмд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан болно.	"Энэхүү стандартын тухай" хэсгээс үзнэ үү.	

Тодорхойлолт

Энэхүү стандартын зорилгын үүднээс дараах тодорхойлолтыг хэрэглэх бөгөөд эдгээр нь SFA-ийн Нэр томъёоны тайлбар тольд орсон дүйцэх тодорхойлолтоос ялгаатай байж болно.

Малын гаралтай ширхэгт – (энэхүү стандартын зорилгын үүднээс) хөхтөн амьтны гаралтай уургийн ширхэгтийг хэлэх бөгөөд ноос зэрэг эдгээр ширхэгт нь холтослог давхарга (cortex), гадаргуун давхарга (cuticle), голлог (medulla) гэсэн бүтцийн бүрэлдэхүүн хэсгээрээ онцлогтой бөгөөд ноолуурын ямаа (дотор ноос, хялгас), тэмээн хэлбэртэн, сарлаг, альпака, бизон, хонь, ангор зэргээс гарган авдаг. Эдгээр ширхэгт нь механик шинж чанараар хангаж, эсийг хамгаалдаг бөгөөд чийг шингээх өндөр чадвартай. Гарал үүслээр нь малын гаралтай ширхэгтийг үс болон ялгаралт гэсэн хоёр үндсэн төрөлд ангилдаг. Малын гаралтай ширхэгтийг физик, хими, механик шинж чанараас нь хамаарч полимер матрицад бэхжүүлэгч болгон ашиглах боломжтой. Мөн уян хатан чанар, дулаан хадгалалт, үс шингээлт, зөөлөн гялбаа сайтай тул нэхмэлийн сайн түүхий эд болдог. Ширхэгтийн голч, урт нь төрөл зүйлээс хамаарна.

Хоёрдогч боловсруулалт – энэхүү Стандартад хамаарах боловсруулалтын бүх үе шатыг [13 дугаар Хэсэгт](#) заасан. Эдгээр нь малын гаралтай ширхэгтийг самнах, ээрэх, будах болон эцсийн боловсруулалт хийхтэй холбоотой нойтон үйл ажиллагаа юм. Хоёрдогч нойтон боловсруулалтын үйл ажиллагааг аж ахуйн нэгжийн баталгаажсан хамрах хүрээний дотор гүйцэтгэх бөгөөд үүнд будах, цайруулах, угаах, зайлах, усан суурьт бэлтгэл ажиллагаа болон нойтон химийн эцсийн боловсруулалт багтана.

Үүнд үйлдвэрлэл (эсгэх, оёх, түүнчлэн хувцас, гоёл чимэглэл, дэвсгэр хэрэглэл зэрэг эцсийн бүтээгдэхүүнийг оёх ажиллагаа) хамаарахгүй.

Жижиг байгууллага – тухайн улсынхаа хууль тогтоомж, эдийн засгийн бодлогоор жижиг байгууллагад тооцогддог бөгөөд үүнийг баталгаажуулагч Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нотолсон аж ахуйн нэгж. Жишээг [Хавсралт 4](#)-өөс үзнэ үү.

Дахин боловсруулалт – үйлдвэрлэл буюу боловсруулалтын явцад хаягдлын урсгалаас гаргаж авсан, дараа нь цуглуулж, дахин боловсруулж, түүхий эд болгон ашигласан малын гаралтай ширхэгт буюу малын гаралтай ширхэгтэн нэхмэлийн материал (SFA-ийн Нэр томъёоны тайлбар толь).

Хэрэглээний дараах дахин боловсруулалтын хувьд даавууг хэрэглэгч ашигласны дараа цуглуулж, задалдаг.

Хуванцар – газрын тос, байгалийн хий зэрэг чулуужсан түлшнээс гаралтай нефть химийн бүтээгдэхүүнээс гарган авч, хайлуулан ширхэгт, утас, даавуу болгон ээрсэн синтетик полимер. Эдгээр материалыг нийтлэг байдлаар синтетик нэхмэл гэж нэрлэдэг бөгөөд үүнд полиэстер, нейлон, акрил, спандекс/эластан, полипропилен багтана.

1. Хамрах хүрээний шаардлага

- 1.1. «SFA Certified» малын гаралтай ширхэгт боловсруулж буй бүх аж ахуйн нэгж тухайн малын гаралтай ширхэгтийн хувьд «SFA Certified» бүтээгдэхүүний борлуулалт, шошголт болон/эсхүл боловсруулалттай холбоотой мэдэгдэл гаргахаас өмнө зөвшөөрөгдсөн, итгэмжлэгдсэн гуравдагч талаар (өөрөөр хэлбэл ТҮБ) энэхүү стандарт, эсхүл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй түүний өмнөх аль нэг хувилбарын дагуу тухайн төрлийн малын гаралтай ширхэгтэд баталгаажсан байна.
- Аж ахуйн нэгж гэсэн ойлголт болон энэхүү баримт бичигт хэрэглэсэн бусад нэр томъёоны тодорхойлолтыг SFA-ийн Нэр томъёоны тайлбар тольноос үзнэ үү.*
- 1.2. Гэрчилгээ тус бүр нэг төрлийн малын гаралтай ширхэгтийг хамарна. Хэрэв аж ахуйн нэгж «SFA Certified» малын гаралтай ширхэгтийн нэгээс олон төрлийг үйлдвэрлэхээр баталгаажихыг хүсвэл өөр нэг хамрах хүрээний гэрчилгээ авах шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг SFA-ийн Үнэлгээ, баталгаажуулалтын гарын авлагаас үзнэ үү.
- 1.3. Тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнд үйлчилж буй хууль, журмыг үргэлж мөрдөнө. Стандартын шаардлага нь хууль/журмаас илүү өндөр байвал Стандартын шаардлагыг биелүүлнэ. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй улсын хууль тогтоомжтой энэхүү Стандартын шаардлага зөрчилдөж байвал тухайн улсын хууль давуу эрхтэй байна.
- Энэ нь тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнээс гадуур үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд аж ахуйн нэгжийг чөлөөлөх үндэслэл болохгүй.*
- Худалдагч тал нь холбогдох бүх стандарт буюу SFA-ийн Малын гаралтай ширхэгтийн стандарт болон Мөшгөлтийн тогтолцооны стандартын заавал биелүүлэх шаардлагыг хангасан тохиолдолд л бүтээгдэхүүн «SFA Certified» бүтээгдэхүүн болно.*
- 1.4. Ширхэгтийг холих, хольцлох ажиллагаа болон гаргасан мэдэгдэл нь SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (CoC — [Хавсралт 3](#)-ыг үзнэ үү) болон [Хавсралт 6](#)- д нийцсэн байна.
- Мөшгөлтийн тогтолцооны стандарт шинэчлэгдсэн тохиолдолд шинэчилсэн стандартын холбогдох заалт үйлчилнэ.*
- 1.5. Жижиг хэмжээний байгууллага (энэхүү стандартын [Хавсралт 4](#) дэх тодорхойлолтыг үзнэ үү) нь энэхүү стандартын шаардлагыг биелүүлэхдээ [Хавсралт 4](#)-т заасан зохицуулалтыг ашиглаж болно.

2. Баталгаажуулалтын шаардлага

- 2.1. Аж ахуйн нэгж нь энэхүү стандартын «shall (заавал биелүүлэх)» хэмээн заасан бүх шаардлагыг (үзүүлэлтийг) хангасан байна.
- 2.2. Аж ахуйн нэгж эдгээр бүх шаардлагыг хангасан тохиолдолд «SFA Certified» гэж үзнэ.

- 2.3. Аж ахуйн нэгж нь аудит бүрд энэхүү стандартын заавал биелүүлэх (shall) шаардлагаас гадна стандартад заасан дор хаяж гурван шинэ сайжруулалтын үзүүлэлтийг хангасан байна. Сонгосон сайжруулалтын үзүүлэлтүүд тасралтгүй, идэвхтэй хэрэгжиж буйг аудитаар нотолно.
- *Сайжруулалтын үзүүлэлт гэдэг нь «тау» хэлбэрээр тодорхойлсон заалтуудыг хэлнэ. Энэхүү стандартын заавал биелүүлэх шаардлагаас гадна эдгээр бүх шаардлагыг хангасан аж ахуйн нэгжийг «SFA Certified» гэж үзэх бөгөөд «SFA Best Practice»-ийг хангаж байгаа гэсэн мэдэгдэл гаргаж болно.*
- *«тау» үзүүлэлт болон «should» заалтыг (Хавсралт 7-д тусад нь жагсаасан) хоёуланг нь хангасан аж ахуйн нэгжийг SFA-ийн тэргүүлэгч байгууллага гэж үзэх бөгөөд аудит хийх давтамжийг цөөрүүлэх байдлаар урамшуулна.*
- 2.4. [14](#), [15](#), [16](#) дугаар Хэсгийн дагуу боловсруулсан дахин боловсруулсан ширхэгт нь «SFA certified recycled fibre» гэж баталгаажих эрхтэй байна. [Хавсралт 6](#)-г үзнэ үү.
- 2.5. Нотолгооны үйл ажиллагаа явуулахдаа [Хавсралт 5](#)-д заасан нотлох баримтын дүйцлийг ашиглаж болно.

3. Засаглал ба удирдлага

- 3.1 Аж ахуйн нэгж нь энэхүү стандартын бүх шаардлагыг хамарсан, баримтжуулсан удирдлагын тогтолцоог нэвтрүүлж хэрэгжүүлнэ.
- 3.1.1 Аж ахуйн нэгж нь өөрийн хамрах хүрээний гэрчилгээг хариуцах бөгөөд хамрах хүрээний гэрчилгээнд хамрагдах бүх үйл ажиллагаа нь стандартын заавал биелүүлэх бүх шаардлагад нийцэж буйг хангана.
- 3.1.2 Аж ахуйн нэгж нь 2.3-т заасны дагуу сайжруулалтын үзүүлэлтүүдийг тогтоож, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад байгааг харуулснаар тасралтгүй сайжруулалтын зарчмыг баримталж буйгаа нотолно.
- 3.1.3 Аж ахуйн нэгж нь жижиг байгууллага, босоо тогтолцоот компани, эсхүл дангаараа үйл ажиллагаа явуулдаг бие даасан хувь хүн байж болно.
- 3.2 Аж ахуйн нэгж нь удирдлагын оффис нь байрлаж буй улсдаа хуулийн этгээд буюу хууль ёсны хувь хүн байна.
- 3.3 Аж ахуйн нэгж нь SFA-ийн «Ширхэгт боловсруулах» стандартын шаардлагыг хангах ерөнхий хариуцлагыг хүлээх удирдлагын төлөөлөгчийг томилно.
- *Энэ нь аж ахуйн нэгж SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын шаардлагыг хангахыг хариуцсан (SFA-тай харилцах цэг) тэр хүн байж болно.*
- 3.4 Аж ахуйн нэгж нь удирдлагын төлөөлөгчид гарсан аливаа өөрчлөлтийг ажлын 20 хоногийн дотор ТҮБ болон SFA-д мэдэгдэнэ.
- *SFA-д standards@sustainablefibre.org хаягаар мэдэгдэнэ.*
- 3.5 Түүхий эд хүлээн авахтай холбоотой ажиллагааны стандарт журам (SOP)-ыг дараах үйл ажиллагааны хувьд баримтжуулж, шаардлагын дагуу шинэчилнэ:
- а. эдэлж боловсруулах;

- b. анхан шатны болон хоёрдогч боловсруулалт;
- c. байгаль орчны болон химийн бодисын менежмент;
- d. сургалт;
- e. тасралтгүй сайжруулалтын төлөвлөлт (сайжруулалтын үзүүлэлтийг ашиглан);
- f. шударга хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлт;
- g. хүний нөөцийн бодлого;
- h. чанарын менежмент;
- i. нийлүүлэлтийн сүлжээний менежмент;
- j. дахин боловсруулалт.

Жишээ нь – Засаглалыг байгууллагын бүтцээр дүрсэлж болох бөгөөд түүвэрлэлт, сорилт, мониторинг, чанарын менежментийн ажиллагааны стандарт журмыг нэгтгэж болно. Химийн бодисын менежмент болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тохиромжтой бол хослуулж болно.

- 3.6 Аж ахуйн нэгж нь бүртгэлийг дор хаяж зургаан жил хадгална.
- 3.7 Тогтвортой байдлын зорилтуудын гүйцэтгэлийн гол үзүүлэлт (KPI)-ийг тогтоож, шаардлагын дагуу дахин хянаж болно.
- 3.8 Дотоод аудитын хүрээг бүрдүүлж, дотоод аудитыг жил бүр хийх бөгөөд үүрэг, хариуцлага, бодлого, журмыг тодорхойлж, бүртгэж болно.
- Заавар – Дотоод аудитын тогтолцоог хөгжүүлэх, хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг [Хавсралт 1](#)-ээс үзнэ үү.
- 3.9 Боловсруулалт гүйцэтгэж буй туслан гүйцэтгэгчийг энэхүү стандартын холбогдох шаардлагатай тулган үнэлнэ.
- 3.10 Тогтвортой байдлын гүйцэтгэлийг олон нийтэд тайлагнаж болно.
- 3.11 Аж ахуйн нэгж нь өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн харилцаанаас үүдэн гарах сөрөг үр нөлөөг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах, арилгах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоонд нийцүүлэн ([Хавсралт 2](#)-ыг үзнэ үү) тасралтгүй сайжруулалт болон хариуцлагатай бизнесийн зан үйлд үзүүлэх нөлөөг үнэлэх, эрсдэлд суурилсан үйл явцыг бий болгож болно.
- 3.12 3.11-ийг биелүүлэх талаар худалдан авагч, худалдагч хоёр худалдан авагчийн худалдаанд тавих шаардлагад үндэслэн харилцан тохиролцож болно. Гэхдээ энэхүү стандартыг хэрэгжүүлэх эхний үе шатанд үүнийг сайжруулалтын үзүүлэлт болгон хүлээн зөвшөөрөхийг зөвлөж байна. Үнэлгээний дүгнэлтийг аж ахуйн нэгжийн тогтвортой байдлын зорилтод тусган, дотоод аудитаар нотлох боломжтой.
- Энэхүү үнэлгээг нийлүүлэлтийн сүлжээний туршид өргөжүүлж, одоо мөрдөж буй засаглал, удирдлагын тогтолцоонд нэгтгэвэл зохино.
- Заавар – See [Хавсралт 2](#)-ыг үзнэ үү.

- 3.13 Хэрэглээнээс өмнөх болон хэрэглээний дараах дахин боловсруулсан ширхэгтийг боловсруулж буй аж ахуйн нэгж нь 3.11-д заасан шаардлагыг хангана.

4. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал ба ариун цэвэр

- 4.1. Хуулийн бүх шаардлагыг хангасан эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого, журамтай байна.
- 4.2. Тэмдэг, тэмдэглэгээ тодорхой байх бөгөөд аюулгүй байдлын мэдээллийг ажилтан бүрд ойлгомжтой хэлбэр, хэлээр хүргэнэ.
- 4.3. Ажлын байрны аюулын албан ёсны эрсдэлийн үнэлгээг жил бүр хийж, болзошгүй эрсдэлийг арилгах арга хэмжээ авна. Эрсдэлийн үнэлгээнд дараахыг харгалзан үзнэ:
- а. зорилт;
 - б. аюулын үнэлгээ;
 - с. тэдгээрийн давтамж, цар хүрээ, үр дагавар;
 - д. урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ.
- 4.3.1. Зөрчил гарсан тохиолдолд залруулах арга хэмжээг бүртгэнэ.
- 4.4. Эрсдэлийн үнэлгээг жил бүр дахин хянаж, шинэчлэх бөгөөд дараах зүйлс үүсэх магадлалыг багтаана:
- а. тоосонд өртөх;
 - б. халтирч, бүдрэн унах;
 - с. дуу чимээний бохирдол;
 - д. ганцаараа ажиллах;
 - е. хэт ягаан туяанд өртөх (байгалийн болон зохиомол);
 - ф. галын аюулгүй байдал;
 - г. гэмтэл бэртэл;
 - h. хөдөлгөөнт машин механизм.
- 4.5. Аж ахуйн нэгж нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, жирэмсэн эмэгтэй болон эмзэг бүлгийн ажилтанд зориулсан нөхцөлийн хүрэлцээг хангана.
- 4.5.1. Эрсдэлийн үнэлгээнд урьдчилан сэргийлэх/бууруулах дараах арга хэмжээг тодорхойлсон байна:
- а. тоосны хэмжээ ихсэх үед тоосны маск зүүх шаардлага;
 - б. үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, үйл явц буюу ажлын нөхцөлд томоохон өөрчлөлт гарсан үед; эсхүл ноцтой осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин тохиолдсоны дараа;

- c. үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, үйл явц буюу ажлын нөхцөлд томоохон өөрчлөлт гарсан үед; эсхүл ноцтой осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин тохиолдсоны дараа;
 - d. шинэ эрсдэл мэдэгдсэн/илэрсэн үед.
- 4.6. Машин механизмыг мэргэжлийн түвшинд суурилуулж, үйлдвэрлэгчийн зааврын дагуу ашиглах бөгөөд чухал ач холбогдол бүхий машин механизмын хувьд дор хаяж жил бүр, мөн шинэ машин механизм/тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах эхэн үед хийх эрсдэлийн үнэлгээнд хамруулж, 3 жил тутамд багтаан шинэчилсэн байна.
- 4.7. Бага оврын тоног төхөөрөмжийн засварын бүртгэлийг хөтөлж хадгална.
- 4.8. Бүх үйл ажиллагаанд ашиглах машин механизм, тоног төхөөрөмж нь дараах байдалтай байна:
 - a. компанийн бодлого (үйлдвэрлэгчийн заавар)-ын дагуу тогтмол засвар үйлчилгээнд хамрагдсан байх;
 - b. бүх тоног төхөөрөмжийн шинэчилж хөтөлсөн бүртгэлийн дэвтэртэй байх;
 - c. хамгаалалт, хаалт, хашлага болон аюулгүй байдлын хэрэгслээр тоноглогдсон байх;
 - d. тодорхой шошго наасан байх;
 - e. машин механизмыг аюулгүй ажиллуулах заавар нь операторт ойлгомжтой, гар дор бэлэн байх.
- 4.9. Аж ахуйн нэгж нь дараах чиглэлээр чадамжтай, хариуцлага хүлээх ажилтан, гэрээт гүйцэтгэгч/гадны үйлчилгээ үзүүлэгчийг томилно:
 - a. эрүүл мэнд, аюулгүй байдлын дадал;
 - b. хөдөлмөрийн аюулгүй байдал;
 - c. ажлын нөхцөлийг сайжруулах;
 - d. хууль тогтоомж болон энэхүү стандартын шаардлагын хэрэгжилт, түүнд тавих хяналт.
- 4.10. Цэвэр, аюулгүй ажлын нөхцөлийг бүрдүүлж, дараахаар хангана:
 - a. ариун цэврийн байгууламж;
 - b. ундны ус;
 - c. хангалттай амралтын өрөө;
 - d. хоол хүнс хэрэглэх нөхцөл.
- 4.11. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдах боломжийг үргэлж хангах бөгөөд үүнд дараах багтана:
 - a. анхны тусламжийн хайрцаг;
 - b. эрүүл мэндийн үзлэг (бүх ажилтныг жил бүр хамруулахыг зөвлөж байна);

- с. эмнэлгийн яаралтай тусламж шаардсан тохиолдол болон осол гарсан үед орон нутгийн эмнэлгийн байгууллагад хүргэх тохиромжтой тээврийн хэрэгсэл.
- 4.12. Бүх ажилтныг ажил олгогчийн зардлаар эмнэлгийн даатгалд хамруулж болно.
- 4.13. Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэлийг баримтжуулж, хадгална.
- 4.14. Хамгаалах хувцас, хэрэгслийг ажилтнаас төлбөр авахгүйгээр олгоно.
- 4.15. Хамгаалах хувцас, хэрэгслийг хэрэглэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:
 - а. салбарын хүлээн зөвшөөрөгдсөн чанарын стандартад нийцсэн байх;
 - б. тогтмол засвар үйлчилгээнд хамрагдсан, үр дүнтэй, ашиглахад аюулгүй байх;
 - с. шаардлагатай үед солигдсон байх.
- 4.16. Бүх ажилтныг ажлын байрны аюулгүй байдлын бодлого, журмын талаар сургалтад хамруулна.
 - 4.16.1. Сургалтыг жилд дор хаяж нэг удаа, мөн шинэ ажилтан ажилд авах бүрд зохион байгуулна.
- 4.17. Сургалтад хамрагдсан болон түүнийг дүүргэсэн тухай бүртгэлийг хөтөлж, дор хаяж зургаан жил хадгална.
- 4.18. Осолд хүргэж болзошгүй байсан тохиолдлыг бүртгэж, мэдээлэх бөгөөд авсан арга хэмжээний нотолгоог бүртгэнэ.
- 4.19. Дуу чимээнд өртөх байдлын мониторинг хийж болно.
- 4.20. Аюулгүй байдлын дижитал мониторингийн тогтолцоог ашиглаж болно.
- 4.21. Аж ахуйн нэгж нь зохиомол хэт ягаан туяа болон бусад хортой гэрлийн нөлөөнд удаан хугацаагаар өртөж буй ажилтныг байгалийн гэрэлд гарах боломжтой, тогтмол, хангалттай завсарлагаагаар хангана. 2 цаг өртсөний дараа амралт олгоно.
-  Заавар – Нэмэлт унших материалын хэсгийг үзнэ үү.
- 4.22. Шаардлагатай тохиолдолд эрс тэс цаг агаарын үеийн эрүүл мэндийн менежментийн төлөвлөгөөтэй байх бөгөөд түүнд дараахыг тусгана:
 - а. сүүдэр, хоргодох байраар хангах;
 - б. ажлын цагийг тохируулах;
 - с. хувийн хамгаалах хэрэгсэл (PPE);
 - д. өртөлтийн менежмент;
 - е. ажлын цагийн хоол хүнс;
 - ф. ус, чийгийн хангамж.
- 4.23. Хариуцлага, журмыг тодорхойлсон Онцгой байдлын бэлэн байдлын төлөвлөгөөг бүх ажилтанд ойлгомжтой хэлбэрээр боловсруулсан байна.
- 4.24. Аюултай химийн бодисыг тусгайлан заасан, аюулгүй, шошго бүхий агуулахын талбайд, шаардлагатай тохиолдолд хоёрдогч хамгаалалттайгаар, холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгална ([8 дугаар Хэсгийг үзнэ үү](#)).

5. Хөдөлмөр эрхлэлт, хүний эрх ба шударга хөдөлмөр

- 5.1. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүх шаардлага болон 5 дугаар Хэсгийн шаардлагыг хамарсан хүний нөөцийн (HR) удирдлагын бодлоготой байна.
- 5.2. Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар 15 нас байх бөгөөд хэрэгжүүлж буй практик нь ILO-ийн 138 дугаар конвенцид нийцсэн байна.
- 5.3. ILO-ийн 182 дугаар конвенцийн дагуу 18 нас хүрээгүй хүнээр аюултай ажил гүйцэтгүүлэхийг хориглоно.
- 5.4. Аж ахуйн нэгж нь эрсдэлийг ноцтой байдал, тохиолдох магадлалд нь үндэслэн тодорхойлж, үнэлж, ач холбогдлын дарааллаар эрэмбэлнэ 5.5, 5.6 болон 5.7-д заасан чиглэлийн эрсдэлийг тодорхойлохдоо эрсдэлд суурилсан арга барилыг ашиглана.
- 5.5. Хүний нөөцийн удирдлагын бодлого нь Хөдөлмөрийн тухай хууль (LOL Code) болон/эсхүл холбогдох үндэсний хууль тогтоомжийг тусгасан байх бөгөөд дараах асуудал тус бүрийг шийдвэрлэх удирдамж, тогтолцоог тодорхойлсон системийг бүрдүүлнэ:
- a. тэгш эрх, тэгш боломж;
 - b. цалин хөлс, урамшууллын бодлого;
 - c. ажлын нөхцөл, аюулгүй байдал, ариун цэвэр;
 - d. ялгаварлан гадуурхахгүй байх бодлого (эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүн, гадаадын иргэн, эмзэг бүлэг);
 - e. хүүхдийн болон албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх бодлого;
 - f. ажилд авах журам;
 - g. хөдөлмөрийн гэрээ цуцлах, ажлаас чөлөөлөх журам;
 - h. хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх журам;
 - i. сахилгын шийтгэл ногдуулах, гомдол барагдуулах журам;
 - j. хөдөлмөрийн удирдлага, мониторинг;
 - k. уугуул иргэд болон орон нутгийн иргэдийн эрх.
- 5.6. Хүний нөөцийн удирдлагын бодлогод Боолчлолын эсрэг бодлогыг тусган хэрэгжүүлэх бөгөөд уг бодлогод дор хаяж дараах зүйлийг хориглосон байна:
- a. албадан илүү цагаар ажиллуулах;
 - b. хөлс төлөхгүйгээр илүү цагаар ажиллуулах;
 - c. хууль бусаар цалин хөлсийг дутуу олгох;
 - d. гэрээгээр боолчлон ажиллуулах хөдөлмөр;
 - e. өрийн дарамтад суурилсан хөдөлмөр;

- f. аливаа хэлбэрийн албадан хөдөлмөр;
 - g. хүүхдийн хөдөлмөр;
 - h. хоригдлын хөдөлмөр.
- 5.7. Хүний нөөцийн удирдлагын бодлогод жендерийн тэгш байдлын удирдлагын бодлогыг тусгана. Уг бодлогод дараах зүйлийг харгалзан үзнэ:
- a. бүгдэд тэгш цалин хөлс олгох;
 - b. засаглал/удирдлага дахь жендерийн тэгш байдлын харьцаа;
 - c. шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн саналаа илэрхийлэх байдал;
 - d. ажилд авахад жендерийн тэгш байдлыг хангах;
 - e. эмэгтэйчүүдийн мэргэжлийн хөгжил, албан тушаал дэвших боломж;
 - f. гэр бүлд ээлтэй ажлын орчин;
 - g. хагас цагийн/түр/улирлын чанартай ажлын байраар хангах зохицуулалт;
 - h. аюулгүй ажлын орчин, хөхүүл эхэд зориулсан нөхцөл, жирэмсэн эмэгтэйчүүдийн амралт зэрэг эрүүл мэнд, аюулгүй байдлын тусгай зохицуулалт;
 - i. эмэгтэй ажилтанд хандах ялгаварлан гадуурхахгүй зан үйл, хандлага;
 - j. ILO-ийн 183 дугаар конвенцид заасны дагуу жирэмсний болон амаржсаны амралт олгох;
 - k. бэлгийн дарамт, доромжлол, хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, бууруулах арга хэмжээ.
- 5.8. Эмэгтэйчүүдийн гомдол барагдуулах хороог байгуулж, эмэгтэй ажилтны асуудлыг дээшлүүлэн тавих, шийдвэрлэхэд идэвхтэй оролцуулж болно.
- 5.9. Дарамт, доромжлолыг хориглоно.
- 5.10. Ажилтан бүрд цалин хөлсний дэлгэрэнгүй мэдээлэл, түүний дотор цалинг хэрхэн тооцсон талаарх мэдээллийг олгоно.
- 5.11. Цалин хөлс нь хуулиар тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний шаардлагыг хангасан байна.
- 5.12. Олгосон цалин хөлсний бүртгэлийг хөтөлнө. Уг бүртгэл нь ажилласан цагийг үнэн зөв тусгасан байна.
- 5.13. Ажлын цаг нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.
- 5.14. Ажилтнууд хөдөлмөрийн бүрэн гүйцэд бичгэн гэрээ буюу хамтын хэлэлцээрийг хүлээн авсан байна.
- 5.15. Хүний нөөцийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх, мониторинг хийх, үнэлэх ажлыг томилогдсон ажилтан хариуцна.
- 5.16. Ажлын байрны аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлтийн журам, дүрэм, зохицуулалтыг хамарсан албан ёсны танилцуулга, сургалтын хөтөлбөрийг бүх шинэ ажилтанд зохион байгуулна.

- 5.17. Хүний нөөцийн бодлогыг аж ахуйн нэгжийн хэрэгцээнд нийцүүлэн дахин хянаж, үнэлнэ.
 - 5.18. Хүний нөөцийн удирдлагад оролцдог ажилтнуудыг зохих ёсоор сургасан байна.
 - 5.19. Хүний нөөцийн үнэн зөв, тогтмол хөтөлсөн бүртгэлтэй байна.
 - 5.20. Ажилтны хороо байгуулж болно.
 - 5.21. Ажилтны оролцооны хөтөлбөр нь шийдвэр гаргалтад нөлөөлвөл зохино.
 - 5.22. Илүү цагаар ажиллах нь сайн дурын үндсэн дээр байна.
 - 5.22.1. Ажилласан бүх цагийг цалинжуулна.
 - 5.23. Тэгш боломжийн зорилтын биелэлтэд мониторинг хийж, тайлагнаж болно.
 - 5.24. Амьжиргааны цалингийн үнэлгээ хийж болно.
 - 5.25. Шууд ажилд авсан ажилтнуудын хувьд аж ахуйн нэгж нь хууль тогтоомжид заасан биечлэн таних, ажиллах эрх болон насны нотолгоог хийвэл зохино.
- *Аж ахуйн нэгж нь хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны үнэлгээг Нэгдсэн Үндэстний Байгууллагын «Бизнес ба хүний эрхийн удирдамж зарчим» (UNGP) 17, түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын «Хувцас, гутлын салбарын хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээнд магадалгаа хийх удирдамж»-д тусгасан зарчимтай уялдуулвал зохино.*

6. Чанарын удирдлага

- 6.1. Цэвэр ширхэгт боловсруулах үйл явцтай холбоотойгоор аж ахуйн нэгжийн баримт бичгийн удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон чанарын хяналт-баталгааны албан ёсны журам (QCA) буюу чанарын удирдлагын тогтолцоо (QMS)-г нэвтрүүлж болно.
- 6.2. Шалгалт явуулах арга, залруулах арга хэмжээ, үр нөлөөг дахин хянах ажиллагааг багтаасан, баримтжуулсан хэрэглэгчийн гомдол барагдлуулах тогтолцоог QCA/QMS тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон хөтөлж ажиллуулна.
- 6.3. Эцсийн бүтээгдэхүүнд тавих шаардлага, үзүүлэлт буюу шинж чанарыг тодорхойлсон, түүхий эд/түүхий ширхэгт/утасны чанарын тогтсон стандарттай байна. Эдгээр шаардлагыг худалдан авагч, худалдагч хоёр харилцан тохиролцсон байх бөгөөд чанарын үнэлгээ хийх журамтай байна.
- 6.4. Цэвэр ширхэгт боловсруулах үйл явц тогтвортой байх, энэхүү стандартын шаардлагыг хангахыг баталгаажуулсан ажиллагааны стандарт журамтай байна.
- 6.5. Шаардагдах бүтээмж, чанарын түвшинг тодорхойлж, хангаж, мониторинг хийнэ.
- 6.6. Ажилтнуудыг сургаж, чанарын шаардлагыг мэддэг байлгана.
- 6.7. Чанар, баталгааг томилогдсон ажилтан хариуцах бөгөөд бүх ажилтанд өөрсдийн хангах ёстой чанарын шаардлагыг танилцуулсан байна.
- 6.8. Ширхэгтийн найрлагын талаарх мэдэгдлийг худалдан авагч, худалдагч хоёрын хооронд тохиролцсоны дагуу үргэлж үнэн зөв хөтөлнө.

- 6.9. Чанар, үнэн зөв байдлын шалгуурт харшлахгүй бүтээмжийн зорилт тогтоох замаар үйл явцыг зураглах, оновчлох аргыг нэвтрүүлж болно.
- 6.10. Эхнээс эцсийг хүртэлх цахим мөшгөлтийг нэвтрүүлж болно.

7. Байгаль орчны удирдлага

- 7.1. Хууль тогтоомжийг тусгасан, байгаль орчны зорилтуудыг багтаасан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-тэй байна.
- 7.2. БОМТ-г жил бүр шинэчилнэ.
- 7.3. БОМТ-г хэрэгжүүлэх, мониторинг хийх, үнэлэх ажлыг томилогдсон ажилтан хариуцна.
- 7.4. Бүх ажилтан байгаль орчны удирдлагын тогтолцоог мэдэж, дэмжиж ажиллана.
- 7.5. Тасралтгүй сайжруулалтыг дэмжсэн ажилтнуудын саналыг дэмжиж, авч хэлэлцэн, тохиромжтой тохиолдолд Байгаль орчны төлөвлөгөөнд тусгана.
- 7.6. Эрчим хүч, усыг үр ашигтай хэрэглэх, хаягдлыг хянах ажиллагааг тусгасан ажлын дадлыг нэвтрүүлж болно.
- 7.7. Мониторингоор илэрч болзошгүй эрчим хүч, ус ихээр зарцуулдаг эх үүсвэрийг хянах арга хэмжээтэй байна.
- 7.8. Усны сарын хэрэглээнд мониторинг хийж, бүртгэнэ.
- 7.9. Аж ахуйн нэгж хаалттай эргэлтийн усны системийг ашиглаж болно.
- 7.10. Аж ахуйн нэгж бохир ус цэвэрлэх дэвшилтэт технологи ашиглаж болно.
- 7.11. Эрчим хүчний хэрэглээнд мониторинг хийж, бүртгэнэ.
- 7.12. Чулуужсан түлшний хэрэглээг бууруулах зорилт тогтоож, мониторинг хийн, тайлагнаж болно.
- 7.13. Аж ахуйн нэгж нь чулуужсан түлшний ялгарлыг бууруулах, шинжлэх ухаанд суурилсан буюу эрсдэлд суурилсан зорилт тогтоохоор зорьж болно.
 - Жишээ нь, ирж буй түүхий ширхэгтийн нэг кг тутамд ногдох чулуужсан түлшний ялгарлыг жил бүр х%-иар бууруулах зорилт (KPI) тогтоож болно.
 - Чулуужсан түлшний ялгарлын мониторинг хийхэд зөвлөж буй хэрэгслийг Нэмэлт унших материалын хэсгээс үзнэ үү.
- 7.14. Усны хэрэглээг бууруулах зорилтыг шинжлэх ухаанд суурилсан буюу эрсдэлд суурилсан KPI хэлбэрээр тогтооно.
 - Жишээ нь, аж ахуйн нэгж технологийн усыг дахин ашиглах, дахин боловсруулах зорилтыг дор хаяж 75% байхаар тогтоож болно.
- 7.15. Шинжлэх ухаанд суурилсан буюу эрсдэлд суурилсан, эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилт болон сэргээгдэх/ногоон эрчим хүчний хэрэглээг жил бүр нэмэгдүүлэх төлөвлөгөө тогтоож болно.

■ *Жишээ нь, аж ахуйн нэгж сэргээгдэх эрчим хүчний хэрэглээгээ Х жилийн хугацаанд дор хаяж 80%-иар нэмэгдүүлж болно.*

- 7.16. Бохир усыг салбар нэгж дээрээ цэвэрлэнэ, эсвэл гуравдагч талаар цэвэрлүүлэх зохистой зохицуулалттай байна.
- 7.17. Бохир ус цэвэрлэгээний үр нөлөөг холбогдох хууль тогтоомж, зөвшөөрөл, хаягдал зайлуулах шаардлагатай тулган баримтжуулсан мониторинг, сорилтоор нотолно. Холбогдох үзүүлэлтэд, хамаарах тохиолдолд, дараах багтана:
- a. pH;
 - b. температур;
 - c. химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (COD);
 - d. биологийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (BOD);
 - e. нийт түдгэлзсэн хатуу бодис (TSS);
 - f. орон нутагт зохицуулагддаг бусад аливаа үзүүлэлт. Сорилтыг тогтоосон давтамжтайгаар чадамжтай лаборатори гүйцэтгэнэ.
- 7.18. Аж ахуйн нэгж нь бохир усны үүсэлт болон бохирдуулагчийн ачааллыг цаг хугацааны явцад бууруулах гүйцэтгэлийн зорилт тогтоовол зохино. Үзүүлэлтэд дараах багтаж болно:
- a. боловсруулсан ширхэгтийн нэг килограмм тутамд ногдох усны хэрэглээг бууруулах;
 - b. усыг дахин ашиглах, дахин боловсруулах хэмжээг нэмэгдүүлэх;
 - c. COD, BOD-ийн ачааллыг бууруулах;
 - d. цэвэрлэгээний үр ашгийг сайжруулах;
 - e. лаг үүсэлтийг багасгах;
 - f. цэвэрлэгээний чухал үзүүлэлтэд тасралтгүй мониторинг хийх технологи нэвтрүүлэх.
- 7.19. Бохир усыг шууд зайлуулж байгаа тохиолдолд лабораторийн сорилт хийнэ.
- 7.20. Бохир ус нь орон нутгийн цэвэрлэх байгууламжид холбогдсон тохиолдолд хүчин төгөлдөр зөвшөөрөл болон нийтийн үйлчилгээний нийцлийн бүртгэлийг хөтөлнө.
- 7.21. Байгаль орчны төлөвлөсөн зорилтоос гарсан хазайлтыг залруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 7.22. Амьдралын мөчлөгийн үнэлгээ хийх боломжтой. Хэрэгжүүлэх тодорхой хамрах хүрээ, аргазүйн стандарт, тогтолцооны хил хязгаар, хүлээн зөвшөөрөгдөх нотолгооны төрлийг аж ахуйн нэгж өөрөө тогтоох боломжтой.
- *Амьдралын мөчлөгийн үнэлгээ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний дэлхийн хэмжээнд үзүүлэх нөлөөг түүхий эдийн хэрэглээ, үйлдвэрлэлийн хувиргалт, түгээлт, хэрэглээ, устгал гэсэн үе шатанд задлан үздэг тойрог эдийн засгийн санаачилга юм. Үе шат бүрд дэлхийн дулаарал, нөөцийн шавхагдал, ус, газрын ашиглалт, хоруу чанар ба*

экологийн хоруу чанар, усан сангийн эвтрофикац зэрэг сөрөг нөлөөллийн тодорхой төрөл бүрд оруулж буй хувь нэмрийг хэмждэг.

- 7.23. Байгаль орчны гүйцэтгэлд мониторинг, үнэлгээ хийж, ахиц дэвшил, үр дагавар, тасралтгүй сайжруулалтыг баталгаажуулна.
- 7.24. Байгаль орчны ослыг (жишээ нь, асгаралт) бүртгэж, арилгах арга хэмжээг тогтооно.
- 7.25. Материалыг тойрог эргэлтэд оруулан сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлвэл зохино.
- 7.26. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд [8 дугаар Хэсэгт](#) заасан химийн бодисын менежменттэй холбоотой бүх шалгуурыг тусгана.

8. Химийн бодисын менежмент

- 8.1. Дараахыг багтаасан, баримтжуулсан Химийн бодисын менежментийн тогтолцоо (CMS)-той байна:
 - a. химийн бодисын бүртгэл (инвентор) зэрэг бүх химийн бодисыг үнэлэх үйл явцыг хэрэглэх;
 - b. аюулгүй эзэмших журамд онцгой анхаарах;
 - c. аюултай химийн бодисыг зөөвөрлөх, ашиглах.
- 8.2. Аж ахуйн нэгж нь дараахыг хамарсан, баримтжуулсан эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулна:
 - a. химийн бодис хадгалах;
 - b. эзэмших ба ашиглах;
 - c. ажилтны эрүүл мэндийг харгалзах;
 - d. байгаль орчны нөлөөлөл;
 - e. бүтээгдэхүүний аюулгүй байдал (химийн аюул, өртөлтийн эрсдэл, байгаль орчны нөлөөллийг бүртгэлийн нэг хэсэг болгон тогтолцоотойгоор тодорхойлж үнэлэх замаар);
 - f. тохиромжтой хадгалалтын байгууламж;
 - g. химийн бүх орцын тогтмол хөтөлсөн бүртгэл;
 - h. химийн бодис нь хууль тогтоомжид нийцэж, хэрэглэхэд зөвшөөрөгдөх, аюулгүй болохыг баталгаажуулсан баримт бичиг;
 - i. хууль тогтоомжид нийцсэн ажлын дадал;
 - j. аюултай химийн бодис, аюултай бодисыг аюулгүй эзэмших арга барил болон тэдгээрийн үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан ажилтан;
 - k. химийн бодистой холбоотой ослын үед авах арга хэмжээний журмыг ажилтнууд ойлгосон байх;
 - l. химийн бодистой холбоотой осол гарсан тохиолдолд мөрдөх тусгай журам.

- 8.3. Шинэчилсэн Аюулгүй байдлын мэдээллийн хуудас (SDS) -ыг ажилтнууд хүрч ашиглах боломжтой байрлуулах бөгөөд ялангуяа тухайн химийн бодистой ажилладаг ажилтнуудын ойлгодог хэлээр бэлтгэнэ.
- 8.4. Химийн бодис хадгалах талбайг хууль тогтоомж болон хүлээн зөвшөөрөгдсөн дадалд нийцүүлэн, зохих тэмдэглэгээгээр илэрхий бөгөөд тодорхой тэмдэглэж, найдвартай хамгаалалттай байлгана.
- 8.5. Химийн бодисын бүх савыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүтээгдэхүүний нэршил, аюулын ангилал, эзэмших үеийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг заасан шошгоор тодорхой тэмдэглэнэ.
- 8.6. Хоёрдогч хамгаалалтын (задралыг барих) байгууламжаар хангана.
- 8.7. Химийн бодисыг орлуулах төлөвлөгөөг Химийн бодисын менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлж болно (8.9-ийг үзнэ үү).
- 8.8. Химийн бодисын хэрэглээг хэмжинэ.
- 8.9. Аюултай химийн бодисыг техникийн болон үйл ажиллагааны хувьд боломжтой тохиолдолд хэрэглээнээс гаргах ба/эсхүл илүү аюулгүй хувилбараар орлуулвал зохино.
- 8.10. Биологийн задралд ордог химийн хувилбарыг давуу байдлаар хэрэглэвэл зохино. Мэдээллийг Ном зүй хэсгээс үзнэ үү.
- 8.11. Химийн бодисын менежментийн төлөвлөгөө нь дараахыг харуулсан байна:
- a. аж ахуйн нэгжийн харьяалагдах улсын хууль тогтоомжийн хүрээнд химийн бодис хэрэглэхийг зөвшөөрсөн, хязгаарласан/хориглосон холбогдох зохицуулалтад нийцэж буй байдал;
 - b. химийн орцын хяналт; Үүнийг химийн бодисын Аюулгүй байдлын мэдээллийн хуудсыг шалгаж, тухайн бодисын CAS дугаарыг хүлээн зөвшөөрөгдсөн хязгаарлагдмал бодисын жагсаалттай тулган баталгаажуулах, эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн Үйлдвэрлэлийн хязгаарлагдмал бодисын жагсаалт (MRSL)-д нийцсэн гэрчилгээтэй химийн бодис сонгох замаар гүйцэтгэнэ;
 - c. эцсийн бүтээгдэхүүн нь худалдан авагчийн Бүтээгдэхүүний хязгаарлагдмал бодисын жагсаалт (PRSL), эсвэл түүнгүй тохиолдолд хүлээн зөвшөөрөгдсөн Бүтээгдэхүүний хязгаарлагдмал жагсаалт (MRSL)-д нийцэж буй байдал.
- Хүлээн зөвшөөрөгдсөн RSL-ууд нь:
- [AFIRM RSL](https://afirm-group.com/afirm-rsl/) – <https://afirm-group.com/afirm-rsl/> (PRSL);
 - [Bluesign®](https://www.bluesign.com/) – <https://www.bluesign.com/> (PRSL);
 - [OEKO-TEX® RSL – OEKO restricted substances list](#) (RSL);
 - [ZDHC Manufacturing Restricted Substances List \(MRSL\)](https://www.zdhc.org/mrsl/) – [https://www.zdhc.org/mrsl.](https://www.zdhc.org/mrsl/)
- 8.12. Аж ахуйн нэгж нь Химийн бодисын менежментийн төлөвлөгөөндөө ашиглаж буй химийн бодисын менежментийн тогтолцоог тодорхой заасан байна.

8.13. Дахин боловсруулсан ширхэгт боловсруулахдаа аж ахуйн нэгж дараахын аль нэгийг мөрдөнө:

- a. OEKO-Tex Standard 100 – <https://www.oeko-tex.com/en/our-standards/oeko-tex-standard-100>; or
- b. [Bluesign®](#).

DRAFT

Хүснэгт 1 – Малын гаралтай ширхэгт боловсруулахад химийн бодис хэрэглэхийг зөвшөөрсөн байдал, эцсийн материалд илэрхийлснээр (хуурай жингээр)

Үйл ажиллагаа	Зөвшөөрөгдсөн	Зөвшөөрөгдөөгүй	Хязгаарлагдмал хэрэглээ (зөвшөөрөгдсөн тохиолдолд PPM-ээр илэрхийлсэн хязгаар), хуурай жингээр материалд
Ширхэгт ялгах, задлах	Тоос дарах усан систем	Химийн бодис хэрэглэхийг зөвшөөрөхгүй	Хамаарахгүй
Угаах, цэвэрлэх	- Биологийн задралд ордог ион бус угаагч бодис - APEO агуулаагүй гадаргуугийн идэвхт бодис - Sodium carbonate - Sodium bicarbonate - Citric acid - Acetic acid - Устөрөгчийн хэт исэл (хяналттай хэрэглээ) - Ферментэд суурилсан угаах бодис	- Alkylphenol Ethoxylates (APEOs – includes Nonylphenol ethoxylates (NPEOs) and Octyl phenol ethoxylates (OPEOs) - Alkylphenols (APs) - All perfluoroalkyl and polyfluoroalkyl substances PFAS including perfluorinated stain or water-repellent treatments - Arsenic Compounds - Carcinogenic azo dyes - Biocides: - Dimethyl fumarate (CAS 624-49-7) - O-phenyl phenol (CAS 90-43-7) - Permethrin (CAS 52645-53-1) - Triclosan (CAS 3380-34-5) - Chlorophenols compound (mono, di, tri tetra, penta).	- Фталат - Di-2-ethylhexyl phthalate (DEHP), Dibutyl phthalate (DBP), and Benzyl butyl phthalate (BBP), below 0.1% or 1000 PPM max. - Phenols – Pentachlorophenol (PCP) and Tetra chlorophenol (TeCP) - Tributyltin (TBT) – below 0.5 PPM for Babywear; 1.0 PPM max for all other apparel - Dibutyltin (DBT) - Polychlorinated biphenyls (PCBs) and Polychlorinated terphenyls (PCTs) - Restricted Arylamines –20 PPM max - PFAS: - Below 25 ppb for any PFAS as measured with targeted PFAS analysis (excluding polymer)



Үйл ажиллагаа	Зөвшөөрөгдсөн	Зөвшөөрөгдөөгүй	Хязгаарлагдмал хэрэглээ (зөвшөөрөгдсөн тохиолдолд PPM-ээр илэрхийлсэн хязгаар), хуурай жингээр материалд
		UV-Absorber; UV 350, UV 328, UV 327, UV 320 • Bisphenols (BPF, BPA, BPAF, BPS) (Final concentration in the product should be <10 ppm) • Glycols and glycols ether (See ZDHC MRSL list) • Chlorine/Hercosett process • Chlorinated solvents • Chlorobenzene compounds • Chlorophenols • Dimethyl Fumarate • Short-chain chlorinated paraffins (C10-C13) • Medium Chain Chlorinated Paraffins (C14-C17) • Chromium VI compounds • Lead compounds • Mercury compounds • Cadmium compounds • EDTA	• Below 250 ppb for the sum of targeted PFAS after degradation of precursor (hydrolysis) • Total fluorine below 50 PPM, calculated as Fluorine • Substances that may release formaldehyde (except if final concentration in product is less than 20 PPM for children's garments, underwear, and nightwear; 75 PPM max in all other products) • D4, D5, D6, L3, L4 siloxanes (final concentration in product should be <1000 PPM)



Үйл ажиллагаа	Зөвшөөрөгдсөн	Зөвшөөрөгдөөгүй	Хязгаарлагдмал хэрэглээ (зөвшөөрөгдсөн тохиолдолд PPM-ээр илэрхийлсэн хязгаар), хуурай жингээр материалд
		Organotin compounds	
Будах	- ZDHC MRSL, OEKO-TEX, AFIRM RSL or Bluesign® compliant dyes - Бага нөлөөтэй хүчлийн будаг - Металгүй будаг - Зэс агуулсан будаг (хэрэглээ 5%-иас хэтрэ хгүй).	- Per and Polyfluoroalkyl Substances (PFAS) - Фталат - Азо будаг - Heavy metal dyes except for iron and copper-containing dyes (5% w/w limit for copper-containing dyes) - Heavy Metals including Ni, Cd - Формальдегид - Alkylphenol Ethoxylates (NPEOs) - Chlorinated Organic Dye carriers – those based on trichlorobenzene, biphenyl phenol, ortho-phenylphenol and halogenated aromatic hydrocarbons	
Эцсийн боловсруулалт	- Механик эцсийн боловсруулалтын аргууд - Silicone softeners meeting ZDHC MRSL, OEKO-TEX, AFIRM RSL or Bluesign® requirements		



Үйл ажиллагаа	Зөвшөөрөгдсөн	Зөвшөөрөгдөөгүй	Хязгаарлагдмал хэрэглээ (зөвшөөрөгдсөн тохиолдолд PPM-ээр илэрхийлсэн хязгаар), хуурай жингээр материалд
	- Биологийн гаралтай эцсийн боловсруулалтын бодис - AOX-free super wash finishing as an alternative to the Chlorine/Hercosett process		
Ээрэх — тусгайлан	- Тосон бодис - Статик цэнэгийн эсрэг бодис - Paraffin Wax (Fully refined $\leq 0.5\%$ residual oil content) - Машины тосолгооны материал (хүнд металлгүй) In addition, the above shall meet ZDHC MRSL, OEKO-TEX, REACH,		



Үйл ажиллагаа	Зөвшөөрөгдсөн	Зөвшөөрөгдөөгүй	Хязгаарлагдмал хэрэглээ (зөвшөөрөгдсөн тохиолдолд РРМ-ээр илэрхийлсэн хязгаар), хуурай жингээр материалд
	AFIRM RSL or Bluesign® requirements		
Дахин боловсруулах	OEKO-TEX Standard 100 Bluesign®	PVC Хуванцар Галд тэсвэржүүлэгч: • Polybrominated diphenyl esters (PBDEs), hexabromocyclododecane (HBCDD) • Бусад галогенжүүлсэн төрөл Per and Polyfluoroalkyl Substances (PFAS) Фталат Азо будаг Heavy Metals including Ni, Cd Формальдегид Alkylphenol Ethoxylates (NPEOs) Chlorinated Organic Dye carriers – those based on trichlorobenzene, biphenyl phenol, ortho-phenyl phenol and halogenated aromatic hydrocarbons	

9. Нийлүүлэлтийн сүлжээний менежмент

- 9.1. Аж ахуйн нэгж нь SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын холбогдох бүх шаардлагыг хангасан байна.
- 9.2. Аж ахуйн нэгж нь баталгаажсан ба баталгаажаагүй материалын бохирдол, орлуулалт, санамсаргүй холилдох эрсдэлийн үнэлгээг хийж, баримтжуулах бөгөөд зохих хяналтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Тогтвортой ширхэгтийн боловсруулалтад орсон цэвэр ширхэгтийг тусгаарлаж, шошголж, зохих журмын дагуу хадгална.
- 9.3. Аж ахуйн нэгж нь орц, гарц, нөөцийн хэмжээг тулган тохируулна. Баримтжуулсан таамагласан хөрвүүлэлтийн хязгаараас гадуур гарсан, эсхүл төлөвлөсөн алдагдлын 5%-иас хэтэрсэн, тайлбаргүй аливаа зөрүүг судалж шалган, залруулах арга хэмжээг бүртгэнэ.
- 9.4. Нийлүүлэлтийн сүлжээний зураглалыг шууд нийлүүлэгчдээс цааш өргөтгөж болно.

10. Түүхий эд ширхэгтийг хүлээн авах, ялгах, ангилах

- 10.1. Зохих байгалийн гэрэлтүүлгээр хангасан байна.
- 10.2. Хэт ягаан туяаны нөлөөллийг 4.21-д заасны дагуу удирдан зохицуулж, ном зүйд дурдсан удирдамжийн материалын дагуу хангалттай хаалт хамгаалалт, завсарлага болон өөр хувилбараар хангана. Эдгээр механизмыг аж ахуйн нэгжийн Эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөөнд тодорхой тусгасан байна.
- 10.3. Ирж буй ширхэгт нь 9 дүгээр Хэсэгт заасан нийлүүлэлтийн сүлжээний менежментийн шаардлагын дагуу бэлтгэн нийлүүлэгч хүртэл мөшгих боломжтой бөгөөд таних боломжтой байна.
- 10.4. Ургамлын үлдэгдэл, шороо, хуванцар зэрэг гадны бодис болон бусад бохирдуулагчийг зайлуулна. Ялгах үйл явцын хүрээнд ширхэгтийг задалж, синтетик болон чанар муутай ширхэгтийг зайлуулвал зохино.
- 10.5. Ялгах үйл ажиллагаа нь тусгаарлагдсан, стандартчилагдсан, үр ашигтай байх бөгөөд гүйцэтгэлийн зорилтуудыг тогтоосон, сургалтад хамрагдсан ажилтнаар гүйцэтгүүлнэ.
- 10.6. Чанарын стандарт болон ангиллын шалгуурыг худалдан авагч, худалдагч хоёр харилцан тохирно. Тэдгээрийг ялгах үйл явцад тодорхой, баримтжуулсан хэлбэрээр хэрэглэж, ажилтнуудад танилцуулан мөрдүүлнэ.
- 10.7. Ширхэгтийн чанарын ангилал, төрлийг баримтжуулна. Хариуцсан ажилтныг эдгээр шалгуурын талаар сургасан байвал зохино.
- 10.8. Ялгасан ширхэгтийг тусгаарлаж, жигнэж, зохих ёсоор шошголвол зохино.
- 10.9. Хаягдлыг зохих ёсоор ялган тусгаарлах, устгах ажиллагааг ажиллагааны стандарт журамд тусгасан байна.
- 10.10. Ширхэгтийн алдагдлыг хэмжвэл зохино.

- 10.11. Тоос үүсэхийг практикт боломжтой дээд хэмжээгээр бууруулж, аж ахуйн нэгжийн Эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөвлөгөөнд тусгана.
- 10.12. Ялгасан ширхэгтийг дараагийн үйл явцад шилжүүлэхээр аюулгүй, үр ашигтай цуглуулж зөөнө.

11. Түүхий эд ширхэгтийг угаах, цэвэрлэх

- 11.1. Аж ахуйн нэгж нь угаах үйл явцтай холбоотой дараах баримт бичгийг тодорхой бичиж, ажилтнуудад танилцуулан хэрэгжүүлснийг хангана:
 - a. норгох, угаах, зайлах, хатаахтай холбоотой ажиллагааны стандарт журам;
 - b. чанарын стандарт;
 - c. ангиллын шалгуур.
- 11.2. Угаах үйл ажиллагаа нь үр ашигтай байх бөгөөд гүйцэтгэлийн зорилтуудыг тогтоосон байна.
 - *Үүнийг угаалгын үйл ажиллагааны гарцаар илэрхийлж болно.*
- 11.3. Сарын усны хэрэглээг бүртгэж болно.
- 11.4. Зөвхөн зөвшөөрөгдсөн химийн бодис хэрэглэнэ ([Хүснэгт 1](#)-ийг үзнэ үү).
- 11.5. Машин, тоног төхөөрөмж нь шаардлагад нийцсэн байна, тухайлбал машины хүчин чадал, ажлын даралт, угаалгын мөчлөг, температурын тохиргоо.
- 11.6. Уусмал нь ноосны хөдөлгөөний эсрэг чиглэлд урсдаг угаах шугам (эсрэг урсгалт угаалга) ашиглавал зохино.
- 11.7. Аж ахуйн нэгж нь 7.17 to 7.20-д заасны дагуу арчлан тордсон, үр дүнтэй бохир үс цэвэрлэх системийг ажиллуулна.
- 11.8. Угаасан эцсийн бүтээгдэхүүнийг шаардагдах чанарын стандартын дагуу шалгана.

12. Түүхий эд ширхэгтээс хялгас ялгах

- 12.1. Хялгас ялгах үйл явцтай холбоотой чанарын стандарт, ангиллын шалгуур нь тодорхой байх бөгөөд ажилтнуудад танилцуулан мөрдүүлнэ.
- 12.2. Хялгас ялгах үйл ажиллагаа нь үр ашигтай байх бөгөөд гүйцэтгэлийн зорилтуудыг тогтоосон байна.
- 12.3. Машин болон түүний ажиллах нөхцөл нь хамгаалалттай, шаардлагад нийцсэн байна.
 - *Тухайлбал машины хүчин чадал, цилиндрийн тойрог, агаарын урсгал, чийгшил.*
- 12.4. Ширхэгтийг норгох, угаах, хатаахтай холбоотой ажиллагааны стандарт журамтай байвал зохино.
- 12.5. Шүүлтүүрийн уут, тоос, хаягдлыг хууль тогтоомжийн дагуу цуглуулж, устгана.
- 12.6. Хаягдлыг зохих ёсоор ялган тусгаарлах, устгах ажиллагааг ажлын дадалд нэвтрүүлсэн байна.

12.7. Хялгасыг нь ялгасан ширхэгтийг дараагийн үйл явцад шилжүүлэхээс өмнө мөшгих боломж олгохоор зохих ёсоор шошголно.

12.7.1. Хялгасыг нарийн дотор ноосноос салгах бөгөөд [10](#), [11](#), [12](#) дугаар Хэсэгт заасан анхан шатны боловсруулалтад хамаарах бүх шаардлагыг хангасан тохиолдолд «SFA Certified» гэж үзнэ.

13. Самнах, ээрэх, будах болон эцсийн боловсруулалт (зөвхөн нойтон боловсруулалт)

- 13.1. Ажиллагааны стандарт журам болон үйл явцын хяналтыг баримтжуулж, хэрэгжүүлнэ.
 - 13.2. Химийн бодисын хэрэглээ нь [Хүснэгт 1](#)-д нийцсэн байна.
 - 13.3. Аж ахуйн нэгж нь 7.17-оос 7.20-д заасны дагуу арчлан тордсон, үр дүнтэй бохир үс цэвэрлэх системийг ажиллуулна.
 - 13.4. Бүтээгдэхүүний мөшгөлтийг хангаж хадгална.
 - 13.5. Уусмалын бага харьцаатай будалтыг хэрэгжүүлж, харьцааг бүртгэвэл зохино.
 - 13.6. Технологийн усны эргүүлэн ашиглалтыг дээд хэмжээнд хүргэвэл зохино.
 - 13.7. Эрчим хүчний хэмнэлттэй машин тоног төхөөрөмж ашиглавал зохино.
 - 13.8. Тэг хаягдалд ойртсон (Near Zero discharge) зарчмыг цэвэр тэг ялгарлын удирдамжийн дагуу тогтоож, хэрэгжүүлэх боломжтой.
- Дэлгэрэнгүйг [IWA 42:2022\(en\)](#)-ээс үзнэ үү.
- 13.9. Тоон (дигитал) технологид суурилсан үйл явцын оновчлолын систем, аргыг ашиглаж болно.

14. Дахин боловсруулсан ширхэгт

- 14.1. Дахин боловсруулах зорилгоор ирж буй материалд синтетик хуванцар полимер материал байхгүй байна.
 - 14.2. Амархан салгаж авах боломжтой нэхмэл бүс бүрэлдэхүүн хэсгүүдийг жижиглэн бутлах болон ширхэгт нөхөн авах бусад үйл явцаас өмнө зайлуулна.
- Жишээ нь: хуванцар товч, тэвэн, хавчаар, бэхэлгээ; цахилгаан товч ба түүний эд анги; хуванцар сав баглаа боодол, шошго, пайз, хальс; дэгээ-гогцоот бэхэлгээ; хуванцар суурьтай наамал болон чимэглэлийн хэсэг; хөөс; сав баглаа боодол болон бусад гадны хуванцар материал.
- 14.3. Синтетик ширхэгтэн материал болон малын гаралтай бүс бусад ширхэгтэн материалыг техникийн хувьд боломжтой хэмжээгээр зайлуулна (16.4-ийг үзнэ үү).
 - 14.4. Малын гаралтай ширхэгтэн материалыг дахин боловсруулахад хэрэглэх химийн бодис нь [8](#) дугаар Хэсэгт нийцсэн байна.

- 14.5. Ширхэгтэн материалыг дахин боловсруулж буй аж ахуйн нэгж нь 3.11-д заасан засаглалын шаардлагыг хангана (мөн [Хавсралт 2](#)-ыг үзнэ үү).
- 14.6. Дараахыг нарийвчлан тусгасан бүтээгдэхүүний түршилтын хөтөлбөртэй байна:
- a. түршилтын хамрах хүрээ;
 - b. ашиглах арга;
 - c. давтамж;
 - d. түүвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - e. хүлээн зөвшөөрөх шалгуур;
 - f. үүрэг хариуцлага;
 - g. үл тохирсон үр дүнд авах арга хэмжээ.
- 14.7. Аж ахуйн нэгж нь баталгаажсан бүтээгдэхүүн дэх дахин боловсруулсан материалын гарал үүсэл, мөшгөлт, тоо хэмжээг шалган баталгаажуулах баримтжуулсан тогтолцоог хэрэгжүүлж, тогтмол хөтөлнө.
- 14.8. Аж ахуйн нэгж нь дахин боловсруулах зорилгоор ирж буй бүх материалын эх үүсвэр, төрлийг нотлох бүртгэлийг хөтөлнө.
- 14.9. Аж ахуйн нэгж нь дахин боловсруулсан материалыг хүлээн авах, хадгалах, боловсруулах, ачуулах бүх шатанд таних боломжтой байлгаж, шинэ (анхдагч) материалаас тусгаарлагдсан байхыг хангана.
- 14.10. Аж ахуйн нэгж нь худалдан авсан, боловсруулсан, нөөцөд хадгалсан болон борлуулсан дахин боловсруулсан материалын тоо хэмжээ хоорондоо нийцэж байгааг нотлох, баримтжуулсан тогтолцоог хөтөлнө.
- 14.11. Малын гаралтай ширхэгтэн нэхмэлийг дахин боловсруулах үйл явц бүрийн хувьд аж ахуйн нэгж нь нөхөн авсан материалын төрөл, байдал, бохирдол, ширхэгтэн бус бүрэлдэхүүн хэсэг, ширхэгтийн холимог болон ашигласан дахин боловсруулах технологийг харгалзан орцоос гарц руу шилжих таамагласан хөрвүүлэгч факторыг тогтооно. Орц, гарцын тоо хэмжээг бүртгэж, тулган тохируулна. Материалын зөрүү нь баримтжуулсан, техникийн үндэслэлтэй боловсруулалтын алдагдалтай нийцсэн байна. Тогтоосон хөрвүүлэгч фактороос тайлбаргүй буюу хэвийн бус хазайсан тохиолдолд судалж шалган, баримтжуулна.
- 14.12. Аж ахуйн нэгж нь дараах бүртгэлийг хадгална:
- a. нийлүүлэгчийн мэдүүлэг;
 - b. худалдан авалт, борлуулалтын бүртгэл;
 - c. хүлээн авалт болон барааны нөөцийн бүртгэл;
 - d. үйлдвэрлэлийн болон багцын бүртгэл;
 - e. мөшгөлтийн бүртгэл;
 - f. бүтээгдэхүүний мэдэгдэл ба шошго.
- 14.13. Дахин боловсруулсан ширхэгт боловсруулж буй аж ахуйн нэгж нь SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын шаардлагыг мөрдөнө.

15. Хэрэглээнээс өмнөх дахин боловсруулсан ширхэгт

- 15.1. [14](#) дүгээр Хэсгийн бүх шаардлага хэрэглээнээс өмнөх ширхэгтэд хамаарна.
- 15.2. Хэрэглээнээс өмнөх дахин боловсруулсан ширхэгтэн материал нь анхан шатны болон хоёрдогч боловсруулалтын явцад үүссэн малын гаралтай ширхэгтэн бүрэлдэхүүн хэсэг болон малын гаралтай ширхэгт суурьтай нэхмэл материалаас бүрдэнэ.
- 15.2.1. Хэрэглээнээс өмнөх дахин боловсруулсан ширхэгтийг үйлдвэрлэл эсхүл боловсруулалтын явцад хаясан буюу хаягдал гэж тодорхойлсон хаягдлаас нөхөн авч, эцсийн хэрэглэгчид хүрэхээс өмнө дахин боловсруулан түүхий эд болгоно.
- 15.3. Хэрэглээнээс өмнөх дахин боловсруулсан ширхэгтийг гадны нийлүүлэгчээс биш, тухайн боловсруулах үйлдвэрийн дотоод үйл ажиллагаанаас гарган авна. Хэрэглээнээс өмнөх дахин боловсруулсан ширхэгт гэж юуг үзэх талаарх дэлгэрэнгүйг [Хавсралт 6](#)-аас үзнэ үү.
-  Үүнд хаягдал болохоос өмнө тухайн үйлдвэрлэлийн үйл явцын дотор тогтмол дахин ашиглагддаг материал хамаарахгүй ([Хавсралт 6](#)).
- 15.4. Хэрэглээнээс өмнөх дахин боловсруулсан ширхэгтийн агууламжийг дахин боловсруулах алхам бүрд тулган тохируулах бөгөөд гарц нь тогтоосон хөрвүүлэгч факторын 2 %-ийн зөрүүний хязгаарт орцтойгоо тэнцүү байна (14.11-ийг үзнэ үү).
- 15.5. Дахин боловсруулсан эцсийн ширхэгтэн бүтээгдэхүүний чанар нь худалдан авагч, худалдагч хоёрын хооронд тохиролцсоны дагуу байна.
- 15.6. Дахин боловсруулсан ширхэгт нь SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын шаардлагын дагуу бүрэн мөшгих боломжтой байна.

16. Хэрэглээний дараах дахин боловсруулсан ширхэгт

- 16.1. [14](#) дүгээр Хэсгийн бүх шаардлага хэрэглээний дараах дахин боловсруулсан ширхэгтэд хамаарна.
- 16.2. Хэрэглээний дараах дахин боловсруулсан малын гаралтай ширхэгтийг аж ахуйн нэгж нь шинэчлэн хөтөлсөн, баримтжуулсан гэрээт хэлэлцээртэй нийлүүлэгчээс авна.
- 16.3. Аж ахуйн нэгж нь дараахыг хамарсан эрсдэлийн үнэлгээ хийнэ:
- синтетик/малын гаралтай бус ширхэгтэн материал холилдох;
 - тодорхой хэмжээний синтетик ширхэгт зайлшгүй орох;
-  Удирдамж – анхны нэхмэлийн бүрэлдэхүүн хэсэг болсон эсхүл түүнд байнга бэхлэгдсэн эластан, полимер бүрхүүл, мембран, наалдамхай бодис, ламинат болон бусад полимер материалыг салгах нь техникийн хувьд боломжгүй тохиолдолд бүрэн зайлуулах шаардлагагүй. Дахин боловсруулсан материалын ширхэгтийн найрлагыг тодорхойлохдоо тэдгээр агуулагдаж байгааг харгалзан үзнэ.

- c. зөвшөөрөгдөөгүй химийн бодис хэрэглэх;
- d. тодорхойгүй/буруу мөшгөлт;
- e. эрсдэлийг бууруулах арга хэмжээ.

16.3.1. Эрүүл мэндэд аюултай буюу байгаль орчны бохирдуулагч гэж үзэгддэг химийн бодис бүтээгдэхүүнээс уусан гарахгүй болохыг туршилтаар нотлохыг аж ахуйн нэгж эрсдэлийг бууруулах арга хэмжээ болгон хангана.

16.3.2. Аж ахуйн нэгж нь тодорхой хэмжээний синтетик ширхэгт орсон үндэслэлээ тайлбарлах бөгөөд эдгээр материалыг агуулсан түүхий болон боловсруулсан дахин боловсруулсан ширхэгтийн багц бүрийг хамт мэдүүлнэ.

- 16.4. Худалдан авсан хэрэглээний дараах малын гаралтай ширхэгтэн материалын багц бүрийн найрлагыг тодорхойлж, тоо хэмжээг бүртгэнэ.
- 16.5. Аж ахуйн нэгж нь хэрэглээний дараах ширхэгтэн материалыг задлах ба/эсхүл өтгөрүүлэхэд хэрэглэсэн химийн бодисын бүртгэлийг нийлүүлэгчээс авах бөгөөд тэдгээр нь [8 дугаар Хэсэгт](#) нийцсэн байна.
- 16.6. Эцсийн бүтээгдэхүүнд байгалийн бусад ширхэгтэн материал агуулагдаж байгаа тохиолдолд эцсийн материалын найрлагыг шошгон дээр зарлан мэдээлэх бөгөөд ширхэгтэн материалын тооцоолсон тоо хэмжээний тохируулгын харьцаагаар нотлогдох боломжтой байна.

17. Ширхэгтийн түүвэрлэлт, сорилт

- 17.1. Лабораторийн сорилтыг ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори гүйцэтгэнэ.
- 17.2. Сорилтын тоног төхөөрөмж, байгууламжийг цэвэр байлгаж, зохих ёсоор арчлан тордоно.
- 17.3. Багцын дээж, лабораторийн дээж, сорилтын дээжийг тохирох түүвэрлэх аргаар авах бөгөөд эдгээр нь сорилтын шаардлагын дагуу нэг ижил төрлийн ширхэгтийг төлөөлж чадахуйц байна.
- 17.4. Дээж нь шаардагдах стандартад нийцэхгүй бол дээж авах журамд өөрчлөлт оруулбал зохино.
- 17.5. Найдвартай сорилт, ялган тодорхойлох арга техниктэй байвал зохино.
 - Тухайлбал гэрлийн микроскоп (LM) буюу сканнердагч электрон микроскоп (SEM). Ном зүйг үзнэ үү.
- 17.6. Сорилтын арга нь холбогдох үндэсний стандарт, ISO стандарт, ASTM стандарт болон нэхмэлийн технологийн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад аргад нийцсэн байна. Нэмэлт унших материалыг үзнэ үү.
- 17.7. Холбогдох тохиолдолд ширхэгт болон ширхэгтийн хольцыг нарийвчлан ялган тодорхойлж, чанарын болон тоон шинжилгээг хийнэ ([Хавсралт 3](#)-ыг үзнэ үү).
- 17.8. Худалдан авагч, худалдагч хоёрын хооронд тохиролцсоны дагуу захиалагчийн шаардлагад нийцэж буй эсэхээр ширхэгтэд үнэлгээ хийнэ.

- 17.8.1. Ширхэгтийн голч (микроноор), ширхэгтийн урт, чийгийн агууламж, чийг шингээлт, үлдэгдэл тос, ширхэгтийн найрлага зэрэг үзүүлэлтэд сорилт хийж болно.
- 17.9. Ердийн дотоод сорилтыг шалгаж тохируулсан тоног төхөөрөмж, тохиромжтой нөхцөлд, чадамжтай ажилтнаар гүйцэтгүүлнэ.
- 17.10. Дараахыг нарийвчлан тусгасан бүтээгдэхүүний сорилтын хөтөлбөртэй байж болно:
- a. сорилтын хамрах хүрээ;
 - b. хэрэглэх арга;
 - c. давтамж;
 - d. түүвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - e. хүлээн авах шалгуур;
 - f. үүрэг хариуцлага;
 - g. үл тохирсон үр дүнд авах арга хэмжээ.
- 17.11. Түүвэрлэлтийн давтамж нь эрсдэлд суурилсан бөгөөд боловсруулалтын холбогдох үе шаттай уялдсан байна.
- 17.12. Дээж хүлээн зөвшөөрөх журамтай байвал зохино.
- 17.13. Дээж нь шаардагдах стандартад нийцэхгүй бол өөрчлөлт оруулбал зохино.
- 17.14. Сорилтын үнэн зөв, бүрэн тайлан, бүртгэлтэй байна.
- 17.15. Аж ахуйн нэгжийн дотооддоо ажиллуулдаг лаборатори нь [4](#) болон [5](#) дугаар Хэсгийн шаардлагыг хангана.

18. Өгөгдлийн менежмент ба кибер аюулгүй байдал

- 18.1. Аж ахуйн нэгж нь өгөгдөл цуглуулах, боловсруулах, дамжуулах бүх үйл ажиллагааг тухайн улсын холбогдох хууль тогтоомж, өгөгдөл хамгаалах зохицуулалтын дагуу гүйцэтгэнэ.
- 18.1.1. Аж ахуйн нэгж нь дараахад тохирсон түвшний аюулгүй байдлыг хангах, найдвартай техник, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, хөтөлнө:
- a. эрсдэл;
 - b. хуваалцсан бүх өгөгдлийг зөвшөөрөлгүй буюу хууль бус боловсруулалтаас хамгаалах;
 - c. санамсаргүй алдагдал;
 - d. устгагдах;
 - e. эвдрэл гэмтэл.

- 18.2. Аж ахуйн нэгж нь кибер аюулгүй байдлын албан ёсны удирдлагын бодлогыг хэрэгжүүлнэ. Аж ахуйн нэгж нь зөрчлийг бууруулах, өгөгдлийг хамгаалах яаралтай арга хэмжээг авахын зэрэгцээ хохирсон талууд болон ТҮБ-д дөчин найман (48) цагийн дотор мэдэгдэнэ.
- 18.3. Аж ахуйн нэгж нь хүлээн зөвшөөрөгдсөн өгөгдлийн аюулгүй байдлын стандартын дагуу баталгаажсанаар нийцлээ нотолж болно.

■ *Жишээ нь ISO/IEC 27001:2022.*

19. Тасралтгүй сайжруулалт

- 19.1. Аж ахуйн нэгж нь аудит бүрт өмнөх үнэлгээгээр аль хэдийн хангасан сайжруулалтын үзүүлэлтүүдээ үргэлжлүүлэн хангахын зэрэгцээ өмнөх үнэлгээгээр хараахан хангаагүй байсан сайжруулалтын дор хаяж гурван үзүүлэлтийг нэмж хангаснаар, сайжруулалтын бүх үзүүлэлтийг эцэст нь хангах хүртэл тасралтгүй сайжруулалтаа харуулна.
- *Сайжруулалтын зарим үзүүлэлт нь болзолт шинжтэй буюу зөвхөн тодорхой нөхцөлд хамаарна. Сайжруулалтын үзүүлэлт нь тухайн аж ахуйн нэгжид хамаарахгүй бол түүнийг тасралтгүй сайжруулалтыг харуулахад ашиглах боломжгүй.*
- 19.2. Аж ахуйн нэгж нь дараагийн давтан үнэлгээнийхээ үед 2.2 дахь заалтыг хэрхэн хангахаар төлөвлөж буйгаа тодорхойлсон тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөтэй байна.
- *Аж ахуйн нэгж «SFA Best Practice» гэсэн мэдэгдэл хийхээсээ өмнө сайжруулалтын бүх үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай хэвээр байна.*
- 19.3. Жижиг байгууллагад ангилагдсан аж ахуйн нэгжийг [Хавсралт 4](#)-т заасны дагуу зарим шаардлагаас чөлөөлж болно.

Нэмэлт унших материал

1. Analytical approaches and advancement in the analysis of natural and synthetic fibre: A comprehensive review (2025) – [Analytical approaches and advancement in the analysis of natural and synthetic fibre: A comprehensive review - ScienceDirect](#)
2. ISO 18074:2015(en) – Textile-Identification of some animal fibres by DNA analysis method-cashmere, wool, yak and their blends – [ISO 18074:2015\(en\), Textiles — Identification of some animal fibres by DNA analysis method — Cashmere, wool, yak and their blends](#)
3. Methods of Fibre Identification – [9 Methods of Fiber Identification - Testex](#)
4. Textile Industry Restricted Substances List – <https://www.textileindustry.net/restricted-substances-rsl-for-textile-and-apparel/>
5. The Textile Guide: How to replace hazardous chemicals – <https://chemsec.org/reports/the-textile-guide-how-to-replace-hazardous-chemicals/>
6. <https://www.oeko-tex.com/en/news/blog/green-chemistry-sustainable-chemicals-in-the-textile-and-leather-industry/>
7. Countercurrent washing of solids – <https://www.sciencedirect.com/science/article/pii/B9780750645683500419>
8. UV radiation – natural and artificial – https://cdn.who.int/media/docs/default-source/who-compendium-on-health-and-environment/who_compendium_chapter6_01092021.pdf?sfvrsn=eb9eb9e1_5
9. WHO's SunSmart Global UV app – <https://www.who.int/teams/environment-climate-change-and-health/radiation-and-health/non-ionizing/optical-radiation>
10. Lighting at Work – <https://www.hse.gov.uk/pubns/priced/hsg38.pdf>

Annex 1. Дотоод аудитын хүрээг бүрдүүлэх

Зорилго

Аж ахуйн нэгжийн тогтвортой байдлын удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааны практик, тайлагнасан гүйцэтгэл нь тогтвортой байдлын стандартын шаардлагад нийцэж буйд хараат бус баталгаа гаргаж, тасралтгүй сайжруулалтыг дэмжихэд оршино.

- Хүний нөөц хязгаарлагдмал жижиг байгууллага нь дотоод аудитыг нэвтрүүлэх, удирдахын тулд гадны аудиторыг (тухайлбал, зөвлөх, нэг бүлгийн бусад салбар нэгжийн хамтран ажиллагч аудитор, эсхүл салбарын холбоодоор дамжуулан үзүүлэх хамтарсан аудитын үйлчилгээ) татан оролцуулж, мөн баримтжуулсан өөрийн үнэлгээний хяналтын хуудсыг ашиглаж болно.

Хамрах хүрээ

Аудитын хөтөлбөр нь дараахыг хамарвал зохино:

- a. засаглал, удирдлагын үүрэг амлалт;
- b. тогтвортой байдлын бодлого, зорилт;
- c. байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гүйцэтгэлийн шаардлага;
- d. хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх үүрэг;
- e. үйл ажиллагааны хяналт, түүнийг дэмжих журам;
- f. өгөгдөл цуглуулах, мониторинг хийх, тайлагнах үйл явц;
- g. оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагаа;
- h. өмнөх аудит буюу тохиолдлоос үүдэн гарсан залруулах арга хэмжээ.

Аудитын зарчим

Дотоод аудит нь дараах шинжтэй байвал зохино:

- Хараат бус** – аудитор өөрийн гүйцэтгэсэн ажилдаа аудит хийхгүй байвал зохино.
- Бодитой, нотолгоонд суурилсан** – дүгнэлт нь нотлогдох боломжтой мэдээлэлд тулгуурлавал зохино.
- Эрсдэлд төвлөрсөн** – эрсдэл өндөр, үр нөлөө ихтэй чиглэлд аудитын анхаарлыг илүү ихээр хандуулбал зохино.
- Түүштай** – стандарт арга зүй, шалгуурыг хэрэглэнэ.
- Нууцлалыг хангасан** – эмзэг мэдээллийг хамгаална.

Аудитын төлөвлөлт

Аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан жилийн аудитын хөтөлбөр боловсруулбал зохино:

- a. аудитын үйл ажиллагааг эрэмбэлэхдээ эрсдэлд суурилсан хандлагыг хэрэглэнэ;

- b. аудитын давтамж, хамрах хүрээ, шалгуур, аргыг тодорхойлно;
- c. өмнөх аудитын дүгнэлт, тогтвортой байдлын чухал асуудал, аж ахуйн нэгжид гарсан өөрчлөлтийг харгалзана;
- d. тогтвортой байдлын зохих мэдлэгтэй, чадамжтай аудиторыг томилно.

Аудитын үйл явц

Дотоод аудитын үйл явц нь дараахыг агуулбал зохино:

- a. **Бэлтгэл** – шаардлагыг судлан үзэх, зорилтыг тодорхойлох, хяналтын хуудас бэлтгэх, холбогдох нэгжид мэдэгдэх.
- b. **Хээрийн ажил** – ярилцлага хийх, баримт бичиг, бүртгэлийг судлах, үйл ажиллагааг ажиглах, нотлох баримтаас түүвэр авах.
- c. **Үнэлгээ** – тогтвортой байдлын стандарт болон дотоод шаардлагад нийцэж буй тохирлыг үнэлэх.
- d. **Тайлагналт** – дүгнэлтийг тодорхой, бодитойгоор баримтжуулах.
- e. **Дараагийн хяналт** – залруулах арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөг нотлох.

Үл тохирлын ангилал

Үл тохирлыг дараах байдлаар ангилж болно:

- a. **Сайжруулах боломж** – гүйцэтгэлийг бэхжүүлж чадах сайжруулалтууд;
- b. **Бага зэргийн үл тохирол** – нийт тогтолцоог алдагдуулахааргүй, тусгаарлагдсан цөөн тохиолдлын доголдол;
- c. **Ноцтой үл тохирол** – стандартын шаардлагыг хангах чадварт нөлөөлөх томоохон доголдол.

Залруулах арга хэмжээ ба дараагийн хяналт

Аж ахуйн нэгж дараах арга хэмжээг авбал зохино:

- a. үл тохирлын үндсэн шалтгааныг тогтоох;
- b. хариуцах эзэн, хугацааг тодорхой заасан залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;
- c. арга хэмжээний биелэлтэд мониторинг хийх;
- d. дараагийн дүн шинжилгээ буюу аудитын үеэр залруулах арга хэмжээний үр нөлөөг нотлох.

Чадамжийн шаардлага

Дотоод аудитор нь дараахаар дамжуулан чадамжаа харуулбал зохино:

- a. холбогдох тогтвортой байдлын стандартын талаарх мэдлэг;
- b. аж ахуйн нэгжид хамаарах тогтвортой байдлын эрсдэл, үр нөлөөний талаарх ойлголт;

- c. аудитын зарчим, арга техник, тайлагналын сургалтад хамрагдсан байдал;
- d. тасралтгүй мэргэжлийн хөгжил.

Бүртгэл ба баримтжуулалт

Аж ахуйн нэгж нь дараахтай холбоотой баримтжуулсан мэдээллийг хөтөлбөл зохино:

- a. аудитын хөтөлбөр, хуваарь;
- b. аудитын төлөвлөгөө, ажлын баримт бичиг;
- c. аудитын тайлан, дүгнэлт;
- d. залруулах арга хэмжээний бүртгэл;
- e. аудиторын чадамж, хараат бус байдлыг нотлох баримт.

Удирдлагын дүн шинжилгээ

Дотоод аудитын үр дүнг дээд шатны удирдлагад тайлагнаж, удирдлагын дүн шинжилгээний үеэр дараах зорилгоор авч хэлэлцвэл зохино:

- a. тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үр нөлөөг үнэлэх;
- b. тогтолцооны шинжтэй асуудал, шинээр үүсэж буй эрсдэлийг тогтоох;
- c. стратегийн шийдвэр, тасралтгүй сайжруулалтын санаачилгыг мэдээллээр хангах.

Annex 2. Тасралтгүй сайжруулалт болон үр нөлөөний үнэлгээ

Энэхүү үнэлгээ нь бизнесийн харилцаатай нь шууд холбоотой сөрөг үр нөлөө зэрэг аливаа сөрөг үр нөлөөнөөс сэргийлэх/бууруулахад, хариуцлагатай бизнесийн зан үйлийг удирдлагын тогтолцоонд нэгтгэн шингээхэд тусалж, нийлүүлэлтийн сүлжээний туршид ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү үнэлгээ нь тасралтгүй сайжруулалт, эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх практикийг засаглалдаа шингээхэд компаниудад дэмжлэг үзүүлнэ. Ингэснээр ажиллагааны стандарт журам нь тусад нь гүйцэтгэх нийцлийн ажил бус, харин бизнесийн ердийн үйл ажиллагааны нэг хэсэг болох бөгөөд үүний тулд компаниуд дараахыг хийхийг шаардана:

- a. бодлого боловсруулж олон нийтэд ил тод мэдээлэх;
- b. дээд шатны удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой хуваарилах (хэрэгжилт, хяналтыг Удирдах зөвлөлийн түвшинд хариуцах);
- c. хэрэгжилтийг дэмжих зохих нөөц, сургалтаар хангах;
- d. хариуцлагатай бизнесийн зан үйлд тавих хүлээлтийг нийлүүлэгчтэй байгуулах гэрээ болон худалдан авалтын практикт тусгах;
- e. мөшгөлтийн тогтолцоо бүрдүүлэх.

Компаниуд нь [5 дугаар Хэсэгт](#) заасан эрсдэлийг нийлүүлэлтийн сүлжээний туршид тодорхойлж, хамгийн ноцтой бөгөөд тохиолдох магадлал өндөртэй эрсдэлийг дараах аргаар эрэмбэлэх нь зүйтэй:

- a. өөрийн үнэлгээ;
- b. ажилчидтай хийх ярилцлага;
- c. салбар нэгжид зочлох;
- d. оролцогч талуудтай зөвлөлдөх;
- e. нийлүүлэлтийн сүлжээг зураглах.

Холбогдох эрсдэлийг хамрах хүрээг тодорхойлох болон дүн шинжилгээгээр илрүүлбэл зохино. Шаардлагатай тохиолдолд эрсдэлийн хүрээнд бүс нутгийн нөхцөл байдлыг (боловсролын түвшин доогуур, засаглал сул, шилжин ирсэн ажиллах хүчний эзлэх хувь өндөр) хамруулж болно.

Эрсдэл илэрсэн тохиолдолд түүнийг сөрөг үр нөлөөгөөр нь (ноцтой байдал ба тохиолдох магадлал) эрэмбэлж, хамгийн ач холбогдолтой эрсдэлийг баримтжуулсан эрсдэлийн үнэлгээгээр шийдвэрлэвэл зохино. Байгаль орчны бүрэн бүтэн байдал, химийн бодисын хэрэглээ, хаягдал ус зайлуулалттай холбоотой бүх эрсдэлийг эрсдэлийн үнэлгээний хүрээнд тогтоож, эрэмбэлбэл зохино.

Компаниуд нь эрсдэл/оролцооныхоо түвшинд тохирсон арга хэмжээ авах нь зүйтэй бөгөөд үүнд тухайн үйл ажиллагааг зогсоох, сөрөг нөлөөг бууруулахын тулд өөрийн оролцоог таслан зогсоох, нөлөөллөө ашиглах зэрэг арга хэмжээ багтана.

Худалдан авалт, судалгаа хөгжүүлэлт, нийцэл, тогтвортой байдал зэрэг хэлтэс хоорондын хамтын ажиллагааг үялдуулах, салбар дундын багуудыг татан оролцуулж, дотоод чанар, аудитын үйл ажиллагааг сайжруулах санал хүсэлт өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор энэхүү үнэлгээг ажиллагааны стандарт журамд тусгавал зохино.

Дотоод аудит нь өгөгдлийн бүртгэл, бүрэн бүтэн байдлыг хангавал зохино ([Хавсралт 1](#)-ийг үзнэ үү).

Залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, нийлүүлэгчийн чадавхыг бэхжүүлэх, нийлүүлэгчид дарамт учруулж буй худалдан авалтын практикийг өөрчлөх, салбарын санаачилгуудтай илүү өргөн хүрээнд хамтран ажиллах зэрэг арга хэмжээ авах боломжтой.

Компаниуд нь дараахыг ашиглан, хянан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөнд мониторинг хийнэ:

- a. гүйцэтгэлийн үзүүлэлт;
- b. нийлүүлэгчид тогтмол үнэлгээ хийх;
- c. ажилчдын санал хүсэлт;
- d. хараат бус үнэлгээ.

Оролцогч талуудын итгэл, хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд дараах талаар ил тод тайлагнахыг зөвлөж байна:

- a. бодлого, үүрэг амлалт;
- b. тогтоосон тэргүүлэх эрсдэл;
- c. авсан арга хэмжээ;
- d. хүрсэн үр дагавар;
- e. тулгарсан бэрхшээл.

Шаардлагатай тохиолдолд компаниуд дараах залруулан барагдуулах арга хэмжээнд оролцоно:

- a. хохирсон ажилчдад нөхөн олговор олгох;
- b. шударга бусаар ажлаас халагдсан ажилтныг ажилд эргүүлэн авах;
- c. ажлын байрны ослын дараах эмнэлгийн түслэмж үйлчилгээг дэмжих;
- d. гомдол барагдуулах механизмыг бэхжүүлэх.

Жижиг, дунд байгууллага нөөц бололцоо хязгаарлагдмал байж болох тул хэмжээ, чадавхдаа тохирсон түвшинд зохих үнэлгээг хийж, нийлүүлэлтийн сүлжээнийхээ бусад оролцогчидтой хамтарсан хандлагыг баримтлавал зохино.

Салбарын оролцогчид хүчирхэг засаглал бий болгож, эхний шатны (Tier 1) нийлүүлэгчээс цааших ил тод байдлыг нэн тэргүүнд тавьж, дараахыг тодорхойлон нийлүүлэлтийн сүлжээг бүхэлд нь зураглахыг уриалж байна:

- a. нэхмэлийн үйлдвэр;
- b. будах, эцсийн боловсруулалтын байгууламж;
- c. түүхий эд бэлтгэн нийлүүлэгч;

- d. туслан гүйцэтгэгч;
- e. цахим мөшгөлтийн тогтолцоо энэ ажилд дэмжлэг үзүүлж чадна.

Дээд түвшинд компаниуд аудитыг дараахтай хослуулахыг уриалж байна:

- a. ажилчдын дуу хоолой;
- b. үйлдвэрчний эвлэлийн оролцоо;
- c. орон нутгийн оролцогч талуудтай зөвлөлдөх;
- d. нэрээ нууцлан гомдол гаргах суваг бий болгох.

Хөдөлмөрийн эрхийн зөрчлийн ихэнх нь бодит бүс арилжааны шаардлагаас үүддэг тул аж ахуйн нэгжүүдэд дараахыг зөвлөж байна:

- a. захиалгыг сүүлийн мөчид өөрчлөхөөс зайлсхийх;
- b. бодитой хугацаа тогтоох;
- c. үнэ нь хуулиар тогтоосон цалин хөлсийг олгох боломжийг бүрдүүлж байгаа эсэхийг хангах;
- d. худалдан авалт болон тогтвортой байдлын багуудын үйл ажиллагааг уялдуулах.

Нийлүүлэгчтэй харилцаагаа таслан зогсоохын оронд аж ахуйн нэгжүүдээс дараахыг хүсэж байна:

- a. сайжруулалтын төлөвлөгөөг дэмжих;
- b. сургалт зохион байгуулах;
- c. ахиц дэвшлийг хянах;
- d. зөвхөн нийлүүлэгч сайжирч чадаагүй буюу ноцтой зөрчил үргэлжилсэн тохиолдолд л харилцаагаа таслан зогсоох.

Үнэлгээний үйл явц, эрсдэлийн гол чиглэл, хэрэгжүүлсэн арга хэмжээ, гүйцэтгэлийн үзүүлэлт болон үр дүнг тусгасан жилийн тайланг нийтлэх практикийг дэмжиж байна. Иймд олон улсын тогтвортой байдлын стандартад нийцүүлсэн тайлагналын хүрээ нь уялдаа нэгдмэл байдлыг хангахад тус болж чадна. Энэ нь нэг удаагийн нийцлийн арга хэмжээ биш, харин (жил бүр дахин хянадаг) тасралтгүй үргэлжлэх эрсдэлийн менежментийн үйл явц юм.

Компаниуд хариуцлагатай бизнесийн зан үйлийг шийдвэр гаргах үйл явцдаа тусгаж, нийлүүлэгч болон оролцогч талуудтай хамтран ажиллаж, өөрсдийн үйл ажиллагаагаа тасралтгүй хянаж сайжруулж байвал зохино.

Үе шаттай хэрэгжүүлэх тохиромжтой арга барил дараах байдалтай байж болно:

- a. Сөрөг үр нөлөөний үнэлгээ/тодорхойлолтыг бодлого, удирдлагын тогтолцоонд тусгах – бодлого боловсруулах, зөвлөлдөх, бодлогыг гэрээнд тусгах, тогтмол сургалт явуулах, засаглалын хариуцлагыг хуваарилах замаар;
- b. Бодит болон болзошгүй үр нөлөөг тодорхойлох – жилийн аудитын тайланг судлах, бүс нутаг/улс орны онцлогт хамаарах эрсдэлд дүн шинжилгээ хийх, шинжээчдээс зөвлөгөө авах замаар хамрах хүрээг тогтоож, дүн шинжилгээ хийх;

- c. Хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг тодорхойлох – эрсдэл, бэрхшээлийн үндсэн шалтгааныг тогтоох, үйл явцыг баримтжуулах;
- d. Сөрөг үр нөлөөг бууруулах – гол оролцогч талуудтай хэлэлцсэний дараа дотоод аудитын дүгнэлтэд үндэслэн залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийг бууруулахад нийлүүлэгч болон оролцогч талуудад нөлөөлөх, залруулах арга хэмжээний төлөвлөгөөнд саналаа өгөх боломжийг оролцогч талуудад олгох;
- e. Хэрэгжилтийг хянах – арга хэмжээний төлөвлөгөөний үр нөлөөг дүгнэх, өгөгдлийг хянах, судалгаа явуулах, сайжруулалтыг нотолж бүртгэх;
- f. Мэдээлэх – сайжруулалтыг жилийн тайлан болон бусад хэлбэрээр мэдээлэх;
- g. Хохирлыг барагдуулах боломж бүрдүүлэх.

Энэхүү арга барил нь OECD-ийн Удирдамжийг мөрдөхөд дэмжлэг үзүүлэхээс гадна нийлүүлэлтийн сүлжээний тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлж, ажилчдын эрхийг хамгаалж, нэр хүндэд учрах эрсдэлийг бууруулж, бизнесийн урт хугацааны тогтвортой байдлыг бэхжүүлдэг.

Annex 3. Холимогийн талаар энэхүү Стандартад хамаарахаар өөрчлөн авсан SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын холбогдох заалтууд

1. 1.5 дугаар заалтыг тайлбарлахад дараах заалт үйлчилнэ (SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартаас өөрчлөн авсан бөгөөд заалтын дугаарлалтыг CoC стандартаас хэвээр авав):
 - 2.9.7 Бүтээгдэхүүн дэх ширхэгтийн 100% нь «SFA Certified» байхаас бусад тохиолдолд аж ахуйн нэгж уг бүтээгдэхүүнийг «SFA certified» гэж борлуулахгүй.
 - 2.9.8 «SFA Certified» ширхэгт нь малын гаралтай хэд хэдэн ширхэгтийн холимог агуулж байгаа тохиолдолд бүтээгдэхүүн дэх малын гаралтай ширхэгтийн агууламжийн 100% нь «SFA Certified» байж, мөн «SFA Certified» малын гаралтай ширхэгт нь бүтээгдэхүүний найрлагын дор хаяж 5%-ийг эзэлж байхаас бусад тохиолдолд аж ахуйн нэгж уг бүтээгдэхүүнийг «SFA Certified» гэж борлуулахгүй.
 - Жишээлбэл, ороолт нь 70% торго, 30% малын гаралтай ширхэгтээс бүрдэж байвал нийт бүтээгдэхүүн дэх тэрхүү 30% малын гаралтай ширхэгтийн агууламж нь «SFA Certified» малын гаралтай ширхэгт байх ёстой.
 - Өөр нэг жишээ болгон авбал, бүтээгдэхүүн нь 95% ноос, 5% бусад малын гаралтай ширхэгтээс бүрдэж байвал тэрхүү 5% бусад малын гаралтай ширхэгт нь «SFA Certified» малын гаралтай ширхэгт байх ёстой.
2. Дахин боловсруулсан ширхэгтийн холимогийн талаар [Хавсралт 6](#)-г үзнэ үү.

Annex 4. Жижиг байгууллага

«Жижиг байгууллага» гэсэн тодорхойлолтод хамаарахаар мэдэгдэж буй аж ахуйн нэгж нь үүнийгээ ТҮБ-тэйгээ зөвшилцөн, тухайн үлсдаа мөрдөгддөг эдийн засгийн бодлого/хууль зүйн шалгуурыг ашиглан үндэслэлээ гаргана.

Жишээ 1

Байгууллагыг ангилах Монгол Улсын шалгуурыг жишээ болгон үзүүлэв.

Уг шалгуурыг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн (шинэчилсэн найруулга, 2019) 5.1 дүгээр зүйлд заасан. Ангилал нь ажиллагчдын тоо болон жилийн борлуулалтын орлого гэсэн хоёр шалгуурт үндэслэнэ.

Хүснэгт 2 – Монгол Улсын байгууллагын ангилал

Ангилал	Ажиллагчид	Жилийн борлуулалтын орлого (төгрөг)	Ойролцоо дүн (ам.доллар)
Бичил	10 хүртэл	300 сая хүртэл	~83,000 ам.доллар хүртэл
Жижиг	10–50	300 сая – 1.0 тэрбум	~83,000 – 278,000 ам.доллар
Дунд	50–200	1.0 – 2.5 тэрбум	~278,000 – 695,000 ам.доллар

Ам.долларын дүнг зөвхөн жишиг байдлаар, 2026 оны 8 дугаар сарын 7-ны байдлаар 1 ам.доллар 3,598 төгрөгтэй тэнцэх ханшаар хөрвүүлэн үзүүлэв. Хуульд дээд хязгаарыг төгрөгөөр тогтоосон тул ам.доллараар илэрхийлсэн дүн ханшийн өөрчлөлтөөс хамаарч хэлбэлзэнэ.

Жишээ 2

OECD-ийн «Хувцас, гутлын салбар дахь жижиг, дунд үйлдвэр ба хариуцлагатай бизнесийн зан үйл» танилцуулга баримт бичиг

Уг баримт бичигт дараах байдлаар заасан:

- Жижиг аж ахуйн нэгж: 10–49 ажиллагчтай;
- Дунд аж ахуйн нэгж: 50–249 ажиллагчтай;
- Бичил аж ахуйн нэгж: 10-аас цөөн ажиллагчтай.

Жишээ 3

Бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжийн тодорхойлолтын тухай 2003 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн Комиссын 2003/361/ЕС зөвлөмж. (CELEX: 32003H0361)

Зөвлөмжид эхлээд аж ахуйн нэгжийг дараах байдлаар тодорхойлсон:

«Аж ахуйн нэгж гэж эрх зүйн хэлбэрээс нь үл хамааран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй аливаа этгээдийг ойлгоно.»

Хүснэгт 1 – 2003/361/ЕС зөвлөмжийн 2 дугаар зүйл: Хэмжээний босго үзүүлэлт

Ангилал	Ажиллагчид	Жилийн эргэлт	эсхүл балансын нийт дүн
Бичил	<10	≤ 2 сая евро	≤ 2 сая евро
Жижиг	<50	≤ 10 сая евро	≤ 10 сая евро
Дунд	<250	≤ 50 сая евро	≤ 43 сая евро

Мөн уг Зөвлөмжид аж ахуйн нэгж нь бие даасан, түншлэлийн эсхүл холбоо хамаарал бүхий эсэхийг тодорхойлох дүрмийг тусгасан бөгөөд өмчлөлийн холбоо хамаарал байгаа тохиолдолд ажиллагчдын тоо болон санхүүгийн үзүүлэлтийг нэгтгэн тооцох шаардлагатай болж болно. Ингэснээр том компаниуд охин компаниараа дамжуулан зохиомлоор жижиг, дунд аж ахуйн нэгжид тооцогдохоос сэргийлдэг.

Жижиг байгууллагад хамаарах зохицуулалт

- Жижиг байгууллага нэг удаад гурван сайжруулалтын үзүүлэлтийг хангаж болно.
- Мөн [Хавсралт 1, 2](#)-т жижиг байгууллагад зориулан тусгасан зохицуулалтыг үзнэ үү.
- Жижиг байгууллагад 18 сарын хугацааны давтамжтай магадлан хяналтын аудитад хамрагдахыг зөвшөөрнө.

Annex 5. Дүйцэх нотлох баримт

Дүйцэх нотлох баримт нь үр дүнтэй хэрэгжилтийг нотолж байгаа тохиолдолд баримтжуулсан нэмэлт журам шаардахгүй.

Жишээ нь:

- a. тэмдэг, тэмдэглэгээ болон ажлын байрны гэрэл зураг;
- b. видео хяналтын бичлэг;
- c. шинэчилсэн хүснэгт, бүртгэлийн дэвтэр, схем;
- d. үйлдвэрлэлийн бүртгэл;
- e. хууль тогтоомжоор шаардсан бүртгэл, бүртгүүлэлт;
- f. хүчин төгөлдөр зөвшөөрөл болон нийтийн үйлчилгээний нийцлийн бүртгэл;
- g. нэхэмжлэх, худалдан авалтын бүртгэл;
- h. засвар үйлчилгээний бүртгэл;
- i. ажилчид/оролцогч талуудтай хийсэн ярилцлага;
- j. хэвлэн нийтлэл, сэтгүүлийн бүртгэл;
- k. аудитын үеийн шууд ажиглалт;
- l. сорилтын бүртгэл, үр дүн;
- m. байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд оролцдог бусад агентлаг, байгууллагад зориулан буюу тэдгээрээс бий болгосон дараах өгөгдөл, мэдээлэл:
 - i. судалгаа;
 - ii. орон нутгийн засаг захиргаа буюу төрийн хяналт шалгалт;
 - iii. мониторинг;
 - iv. үзлэг шалгалт;
 - v. өгөгдөл цуглуулалт;
 - vi. тайлагнал;
 - vii. нийцэл.
- n. бусад агентлагт зориулан бэлтгэсэн байж болох, нотолгооны нотлох баримт болгон авч үзэхэд тохиромжтой, гэхдээ 3 жилээс хэтрээгүй хугацааны өмнөх өгөгдөл цуглуулалт, тайлан;
- o. хамаарал бүхий түүхэн мэдээлэл, өгөгдлийг судалж, нотолж, аудит/үнэлгээний тайланд ашиглах зорилгоор дэлгэрэнгүй мэдээллийг нь бүртгэнэ;
- p. байгууллагын бүртгэл, тухайлбал:
 - i. ажилтан/нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, хэлэлцээр;
 - ii. цалингийн хуудас;
 - iii. үйл явцын бүртгэл;
 - iv. хурал/шийдвэрийн бүртгэл;
 - v. тусгай зөвшөөрөл/бүртгүүлэлт;
 - vi. байгууллагын бүтцийн схем;

- vii. амралт, чөлөөний бүртгэл;
- viii. сургалтын бүртгэл;
- ix. маргаан шийдвэрлэсэн бүртгэл.

DRAFT

Annex 6. Дахин боловсруулсан ширхэгт

1. Дараахыг хэрэглээнээс өмнөх ширхэгт гэж үзнэ:

- a. савалгааны хаягдал;
- b. самналтын богино ширхэгт (нойл);
- c. ээрэлтийн хаягдал;
- d. утасны хаягдал;
- e. нэхэлтийн хаягдал;
- f. сүлжмэлийн тайрдас;
- g. эсгүүрийн хаягдал;
- h. борлогдоогүйн улмаас хаягдал болгон хаясан даавууны боодол;
- i. үйлдвэрлэлээс гологдсон бэлэн хувцас;
- j. устгахаар шийдвэрлэсэн үйлдвэрлэлийн илүүдэл нөөц;
- k. хэрэв дараах нөхцөлийг хангасан бол:
 - i. хаях зориулалттай байсан;
 - ii. хаягдал болгон цуглуулсан;
 - iii. дахин ашиглахаас өмнө дахин боловсруулалт эсхүл давтан боловсруулалтад орсон байх.

2. Дахин боловсруулсан ширхэгтийн хувьд дараах мэдэгдлийг хийж болно:

Хүснэгт 2 - Дахин боловсруулсан ширхэгтэд зөвшөөрөгдөх мэдэгдэл

Бодит найрлага	SFA-ийн тохирох тайлбар
100% дахин боловсруулсан малын гаралтай ширхэгт	100% SFA дахин боловсруулсан ноолуур/ноос/сарлагийн хөөвөр гэх мэт ширхэгт
95% дахин боловсруулсан малын гаралтай ширхэгт + 5% бусад байгалийн ширхэгт	95% SFA дахин боловсруулсан ноолуур/ноос/сарлагийн хөөвөр гэх мэт ширхэгт
80% дахин боловсруулсан малын гаралтай ширхэгт + 20% бусад байгалийн ширхэгт	80% SFA дахин боловсруулсан ноолуур/ноос/сарлагийн хөөвөр гэх мэт ширхэгт
70% дахин боловсруулсан малын гаралтай ширхэгт + 30% бусад байгалийн ширхэгт	70% SFA дахин боловсруулсан ноолуур/ноос/сарлагийн хөөвөр гэх мэт ширхэгт
Ноосон хувцас + санамсаргүй үлдсэн хуванцар товч	Товчийг салгавал зохино; ширхэгтийн найрлагад тооцохгүй

Annex 7. Сайжруулалтын үзүүлэлтүүд

- 1.9. Жижиг хэмжээний байгууллага (энэхүү стандартын [Хавсралт 4](#) дэх тодорхойлолтыг үзнэ үү) нь энэхүү стандартын шаардлагыг биелүүлэхдээ [Хавсралт 4](#)-т заасан зохицуулалтыг ашиглаж болно.
- 2.7. Нотолгооны үйл ажиллагаа явуулахдаа [Хавсралт 5](#) -д заасан нотлох баримтын дүйцлийг ашиглаж болно.
- 3.1.3. Аж ахуйн нэгж нь жижиг байгууллага, босоо тогтолцоот компани, эсхүл дангаараа үйл ажиллагаа явуулдаг бие даасан хувь хүн байж болно.
- 3.7. Тогтвортой байдлын зорилтуудын гүйцэтгэлийн гол үзүүлэлт (KPI)-ийг тогтоож, шаардлагын дагуу дахин хянаж болно.
- 3.8. Дотоод аудитын хүрээг бүрдүүлж, дотоод аудитыг жил бүр хийх бөгөөд үүрэг, хариуцлага, бодлого, журмыг тодорхойлж, бүртгэж болно.
- 3.10. Тогтвортой байдлын гүйцэтгэлийг олон нийтэд тайлагнаж болно.
- 3.11. Аж ахуйн нэгж нь өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн харилцаанаас үүдэн гарах сөрөг үр нөлөөг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах, арилгах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоонд нийцүүлэн ([Хавсралт 2](#)-ыг үзнэ үү) тасралтгүй сайжруулалт болон хариуцлагатай бизнесийн зан үйлд үзүүлэх нөлөөг үнэлэх, эрсдэлд суурилсан үйл явцыг бий болгож болно.
- 3.12. 3.11-ийг биелүүлэх талаар худалдан авагч, худалдагч хоёр худалдан авагчийн худалдаанд тавих шаардлагад үндэслэн харилцан тохиролцож болно. Гэхдээ энэхүү стандартыг хэрэгжүүлэх эхний үе шатанд үүнийг сайжруулалтын үзүүлэлт болгон хүлээн зөвшөөрөхийг зөвлөж байна. Үнэлгээний дүгнэлтийг аж ахуйн нэгжийн тогтвортой байдлын зорилтод тусган, дотоод аудитаар нотлох боломжтой.
- 4.12. Бүх ажилтныг ажил олгогчийн зардлаар эмнэлгийн даатгалд хамруулж болно.
- 4.19. Дуу чимээнд өртөх байдлын мониторинг хийж болно.
- 4.20. Аюулгүй байдлын дижитал мониторингийн тогтолцоог ашиглаж болно.
- 5.8. Эмэгтэйчүүдийн гомдол барагдуулах хороог байгуулж, эмэгтэй ажилтны асуудлыг дээшлүүлэн тавих, шийдвэрлэхэд идэвхтэй оролцуулж болно.
- 5.20. Ажилтны хороо байгуулж болно.
- 5.21. Ажилтны оролцооны хөтөлбөр нь шийдвэр гаргалтад нөлөөлвөл зохино.
- 5.23. Тэгш боломжийн зорилтын биелэлтэд мониторинг хийж, тайлагнаж болно.
- 5.24. Амьжиргааны цалингийн үнэлгээ хийж болно.
- 5.25. Шууд ажилд авсан ажилтнуудын хувьд аж ахуйн нэгж нь хууль тогтоомжид заасан биечлэн таних, ажиллах эрх болон насны нотолгоог хийвэл зохино.
- 6.1. Цэвэр ширхэгт боловсруулах үйл явцтай холбоотойгоор аж ахуйн нэгжийн баримт бичгийн удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон чанарын хяналт-

- баталгааны албан ёсны журам (QCA) буюу чанарын удирдлагын тогтолцоо (QMS)-г нэвтрүүлж болно.
- 6.9. Чанар, үнэн зөв байдлын шалгуурт харшлахгүй бүтээмжийн зорилт тогтоох замаар үйл явцыг зураглах, оновчлох аргыг нэвтрүүлж болно.
- 6.11. Эхнээс эцсийг хүртэлх цахим мөшгөлтийг нэвтрүүлж болно.
- 7.6. Эрчим хүч, усыг үр ашигтай хэрэглэх, хаягдлыг хянах ажиллагааг тусгасан ажлын дадлыг нэвтрүүлж болно.
- 7.9. Аж ахуйн нэгж хаалттай эргэлтийн усны системийг ашиглаж болно.
- 7.10. Аж ахуйн нэгж бохир ус цэвэрлэх дэвшилтэт технологи ашиглаж болно.
- 7.12. Чулуужсан түлшний хэрэглээг бууруулах зорилт тогтоож, мониторинг хийн, тайлагнаж болно.
- 7.13. Аж ахуйн нэгж нь чулуужсан түлшний ялгарлыг бууруулах, шинжлэх ухаанд суурилсан буюу эрсдэлд суурилсан зорилт тогтоохоор зорьж болно.
- 7.15. Шинжлэх ухаанд суурилсан буюу эрсдэлд суурилсан, эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилт болон сэргээгдэх/ногоон эрчим хүчний хэрэглээг жил бүр нэмэгдүүлэх төлөвлөгөө тогтоож болно.
- 7.18. Аж ахуйн нэгж нь бохир усны үүсэлт болон бохирдуулагчийн ачааллыг цаг хугацааны явцад бууруулах гүйцэтгэлийн зорилт тогтоовол зохино. Үзүүлэлтэд дараах багтаж болно:
- a. боловсруулсан ширхэгтийн нэг килограмм тутамд ногдох усны хэрэглээг бууруулах;
 - b. усыг дахин ашиглах, дахин боловсруулах хэмжээг нэмэгдүүлэх;
 - c. COD, BOD-ийн ачааллыг бууруулах;
 - d. цэвэрлэгээний үр ашгийг сайжруулах;
 - e. лаг үүсэлтийг багасгах;
 - f. цэвэрлэгээний чухал үзүүлэлтэд тасралтгүй мониторинг хийх технологи нэвтрүүлэх.
- 7.22. Амьдралын мөчлөгийн үнэлгээ хийх боломжтой. Хэрэгжүүлэх тодорхой хамрах хүрээ, аргазүйн стандарт, тогтолцооны хил хязгаар, хүлээн зөвшөөрөгдөх нотолгооны төрлийг аж ахуйн нэгж өөрөө тогтоох боломжтой.
- 7.25. Материалыг тойрог эргэлтэд оруулан сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлвэл зохино.
- 8.7. Химийн бодисыг орлуулах төлөвлөгөөг Химийн бодисын менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлж болно (8.9, 8.10-ийг үзнэ үү).
- 8.9. Аюултай химийн бодисыг техникийн болон үйл ажиллагааны хувьд боломжтой тохиолдолд хэрэглээнээс гаргах ба/эсхүл илүү аюулгүй хувилбараар орлуулвал зохино.
- 8.10. Биологийн задралд ордог химийн хувилбарыг давуу байдлаар хэрэглэвэл зохино. Мэдээллийг Ном зүй хэсгээс үзнэ үү.
- 9.4. Нийлүүлэлтийн сүлжээний зураглалыг шүүд нийлүүлэгчдээс цааш өргөтгөж болно.

- 10.7. Ширхэгтийн чанарын ангилал, төрлийг баримтжуулна. Хариуцсан ажилтныг эдгээр шалгуурын талаар сургасан байвал зохино.
- 10.8. Ялгасан ширхэгтийг тусгаарлаж, жигнэж, зохих ёсоор шошголвол зохино.
- 10.10. Ширхэгтийн алдагдлыг хэмжвэл зохино.
- 11.3. Сарын усны хэрэглээг бүртгэж болно.
- 11.6. Уусмал нь ноосны хөдөлгөөний эсрэг чиглэлд урсдаг угаах шугам (эсрэг урсгалт угаалга) ашиглавал зохино.
- 12.4. Ширхэгтийг норгох, угаах, хатаахтай холбоотой ажиллагааны стандарт журамтай байвал зохино.
- 13.5. Уусмалын бага харьцаатай будалтыг хэрэгжүүлж, харьцааг бүртгэвэл зохино.
- 13.6. Технологийн усны эргүүлэн ашиглалтыг дээд хэмжээнд хүргэвэл зохино.
- 13.7. Эрчим хүчний хэмнэлттэй машин тоног төхөөрөмж ашиглавал зохино.
- 13.8. Тэг хаягдалд ойртсон (Near Zero discharge) зарчмыг цэвэр тэг ялгарлын удирдамжийн дагуу тогтоож, хэрэгжүүлэх боломжтой.
- 13.9. Тоон (дижитал) технологид суурилсан үйл явцын оновчлолын систем, аргыг ашиглаж болно.
- 17.4. Дээж нь шаардагдах стандартад нийцэхгүй бол дээж авах журамд өөрчлөлт оруулбал зохино.
- 17.5. Найдвартай сорилт, ялган тодорхойлох арга техниктэй байвал зохино.
- 17.8.1. Ширхэгтийн голч (микроноор), ширхэгтийн урт, чийгийн агууламж, чийг шингээлт, үлдэгдэл тос, ширхэгтийн найрлага зэрэг үзүүлэлтэд сорилт хийж болно.
- 17.9. Дараахыг нарийвчлан тусгасан бүтээгдэхүүний сорилтын хөтөлбөртэй байж болно:
- a. сорилтын хамрах хүрээ;
 - b. хэрэглэх арга;
 - c. давтамж;
 - d. түүвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - e. хүлээн авах шалгуур;
 - f. үүрэг хариуцлага;
 - g. үл тохирсон үр дүнд авах арга хэмжээ.
- 17.12. Дээж хүлээн зөвшөөрөх журамтай байвал зохино.
- 17.13. Дээж нь шаардагдах стандартад нийцэхгүй бол өөрчлөлт оруулбал зохино.
- 18.3 Аж ахуйн нэгж нь хүлээн зөвшөөрөгдсөн өгөгдлийн аюулгүй байдлын стандартын дагуу баталгаажсанаар нийцлээ нотолж болно.

